

БАХАРХАХ ҮЙЛСИЙН ЭЗЭН

БААТАР ТӨМӨР ОЧИР АА ТЭЖ ...

(Түрүүч нь I нүүрт)

Энэ жил түүний хорвоод мэндэлж, хүмүүн заяаг олсны 85 насны ой мөн Төрийн хүндэт харуулын анхны цэрэг хэмээгдэж, торгон цэргээрээ овоглосных нь 55 жилийн ой тохиож буй. Эл мөчид эрхэм генералдаа сүүн цацал өргөхийн хамт энэхүү нийтлэлээ тэрлэн уншигч танаа өргөн барьж буй минь энэ билээ.

Монголын ард түмэндээ “Төрийн торгон цэргүүд” хэмээн өргөмжлөгдсөн Хүндэт харуулын ротын анхны захирагч нь тэр үеийн хошууч, хожмоо БХЯ-ны сайдаар ажилласан төр, цэргийн нэрт зүтгэлтэн, хурандаа генерал Жамсрангийн Ёндон байсан бөгөөд түүний ажигч гярхай нүдэнд, тэрчлэн хүнийг таних, ирээдүйг нь тодорхойлох авьяас, чадварт нь өртсөн цэргийн шилдэг дарга нарын нэг нь Т.Баатар байжээ. Учир нь Т.Баатар цэл залуу 20 насандаа эр цэргийн албыг чухалчлан төрсөн нутаг Говь-Алтай аймгийн Шарга сумаас хүлгийн жолоо залж, дөрөө харшуулсаар Улаанбаатар хотын цэрэг татлагын товчооноо иржээ. Энэ үед тэрхүү цэрэг татлагын товчоонд Хүндэт харуулын ротыг шинээр байгуулж буй, түүнд цөөн тооны цэрэг сонгож авах асуудал ид яригдаж байсан нь түүний сонирхлыг татаж, төрийн ёслол үйлддэг хүндэт харуулын цэрэг болох боломж бий эсэх талаар сураг тавьсан аж. Тухайн цагт Хүндэт харуулын ротын захирагч, хошууч Ж.Ёндон цэргийн албанд иргэсэдтэй уулзаж, овог, нэр, боловсрол, мэргэжил, авьяас сонирхлыг нь судалж явахтай нь Т.Баатар таарч, өөрийн хүсэл мөрөөдлөө эрхэм хошуучид танилцуулах алтан боломж тохиожээ. Тэгэхэд хошууч Ж.Ёндон “Даанч нуруу намхан байна. Дөрвөн салаатай рот шинээр байгуулагдаж байгаа бөгөөд надад таван салаатай байх боломж гарсан бол чамайг дуртайяа авах сан” гээд цааш эргэхдээ ротын орлогчдоо “Энэ эр ч цаашид хэрэг болох хүн байна даа” гэсэн нь түүнд өөрийн мөрөөдлөө биелүүлэх урам зориг өгсөн гэдэг.

Тэртээ 1950-аад оны дунд үед байгуулагдсан Хүндэт харуулын ротыг хүмүүс тэр бүр мэдэхгүй, харин хотын комендат буюу хэв журам сахиулах анги гэдгээр нь илүүтэй мэддэг байжээ. Тухайн үеийн хотын комендат нь Хүндэт харуулаас гадна харуулын рот, хэв журам сахиулах эргүүлийн

хугацаат цэргийн албаа нэр төртэй хаахдаа тухайн үеийн өндөр мэдлэг, ур чадвартай, дүрэмч, жагсаалч ажиллагаагаараа армидаа шигшигдсэн шилдэг офицеруудын үлгэр дуурайлаас хичээнгүйлэн суралцсаны үр дүнд хоёр дахь жилээс салааны захирагчийн орлогчоор дэвшин томилогдож, түрүүч цолоор шагнагдсан нь хожмын офицерын албанд дэвших сэдлийг нь төрүүлсэн ажээ. Улмаар халагдах жилээ офицерын албанд дэвшин харуулын тусгай салааны даргаар томилогдож ажилласан ба дараа жилээс нь буюу 1959 оноос 1 дүгээр буудлагын батальонд салааны дарга, 1960 оноос ротын улс төрийн орлогчоор ажилласан юм. Энэ жилүүдэд ажлын амжилт арвин байсны зэрэгцээ цэргийн хэрэгт сайтар суралцсан, командлах ур чадвараараа бусдыгаа манлайлж явсан түүний амжилтыг үнэлж 1961 оноос Улаанбаатар хотын комендатад Хүндэт харуулын ротын даргаар дэвшүүлэн томилсныг тухайн үеийн дарга, захирагч нарын аливаа хүний хөдөлмөр, зүтгэлийг сайтар үнэлдэг, цаашид өсөх ирээдүйтэй удирдах албан тушаалтныг гярхай таньж чаддаг мэдрэмж, чадвартай нь холбон үзэх учиртай. Тэр бээр өөрийн хариуцсан ротоо сайн удирдаж байсны тод жишээ нь төрийн болон цэргийн ёслол хүндэтгэлийн ажиллагааг үлгэр жишээ гүйцэтгэж ирсний дотор сургуулийн жилийн төгсгөлд явагдсан командлалын шалгалтаар “Армийн тэргүүний рот”-оор шалгарсан амжилтыг үзүүлжээ. Нөгөө талаар тухайн үеийн офицер, даргалах бүрэлдэхүүний мэргэжил, дадлага, ур чадварыг ахиулахад байнга анхаарч байсны бодит илрэл нь түүнийг 1962 онд ЗХУ-ын Солнечногорск хотод Буудлага, тактикийн дээд курст суралцуулснаар тодорч байна. Үнэхээр ч Оросын армийн офицеруудын хувьд “Цэргийн хэргийн академи” хэмээн нэрлэгдсэн тус сургуулийг Монголын Ардын Армийн үе үеийн удирдах бүрэлдэхүүн, шилдэг дарга нар төгссөн бөгөөд нийтлэлийн баатар маань ч тэрхүү түүхийг үргэлжлүүлсэн ажээ. Энэ тухайд Баатар генерал дурсахдаа “Манай ротын анхны дарга байсан Ж.Ёндонгоос эхлээд олон шилдэг цэргийн дарга нар энэ л курсийг төгссөн уламжлалтай. Цэргийн дарга бүхэн өөрийн цэргийн хэргийн ур чадвараа цаг ямагт хөгжүүлж байх учиртайг би энэ л курсээс олж



Хошууч генерал Т.Баатар гэр бүл, үр хүүхдүүдийн хамт

М.В.Фрунзын нэрэмжит Ерөнхий цэргийн академид 1965-1968 онд суралцаж төгссөн юм. Тухайн үеийн офицер бүхний мөрөөдөл болсон тэрхүү академийг амжилт дүүрэн төгссөн түүнд Батлан хамгаалах яам, Армийн командлал өндөр итгэл хүлээлгэсэн ба тэрээр 1968-1969 онд 1 дүгээр мотобуудлагын бригадын оператив тасгийн дарга, 1969-1970 онд 2 дугаар мотобуудлагын бригадын батальоны захирагч, 1970-1976 онд 1 дүгээр мотобуудлагын бригадын штабын даргын албан тушаалд шат дараалан томилогдож ажилласан юм.

Энд тодотгоход түүний томилогдсон албан тушаал бүрдээ эзэн нь байж, цэргийн дүрэм, журмаар хүлээлгэсэн албаны үүргийг ягштал биелүүлж, анги, салбаруудын үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг дээшлүүлж, цэргийн сургалтын үр дүнд, бие бүрэлдэхүүний дадлага, ур чадварыг нэмэгдүүлэх, зэвсэглэл, техник, ар талын хангалт, үйлчилгээг үр дүнтэй зохион байгуулахад онцгой анхаарч, өндөр амжилт гаргаж ирснийг нь дурсан багдах ахмад дайчид олон байдаг юм билээ. Түүнийг нотлох бас нэгэн баримт нь тэр бээр 1976-1978 онд К.Е.Ворошиловын нэрэмжит ЗХУ-ын Зэвсэгт хүчний Жанжин штабын академид амжилттай суралцаж төгссөнөөр тодорхой илэрдэг юм. Ийнхүү цэргийн өндөр, дээд

томилогдсон байлаа. Бригадын штабын дарга, дэд хурандаа Ү.Хүрэлтогоо, улс төрийн хэлтсийн дарга, дэд хурандаа Г.Самдан, техникийн орлогч, хурандаа Ч.Чимэддорж, ар талын орлогч, дэд хурандаа Ч.Төрмөнх нарын өөрийн хариуцсан ажлаа төгс мэддэг дарга нартай сэтгэл нийлэн ажиллаж эхэлсэн. Миний өмнөө тавьсан гол зорилт нь ажил, албатайгаа богино хугацаанд танилцаж, яаралтай шийдвэрлэх гол гоцроо асуудлыг барьж, өөрөөсөө шалтгаалах бүхнийг хийх явдал байлаа. Намайг шинэхэн ажлаа авахад олон арван зөрчилтэй асуудал тулгарсан хэдий ч өөрийн орлогч нар, ангиудын захирагч, штабын дарга нар, бусад удирдах албан тушаалтнуудыг байнгын үүрэг, зааварчилгаагаар ханган хяналт шалгалтыг нь тогтмолжуулж, хамт олны сэтгэлд нийцсэн бүтээлч ажлуудыг өрнүүлэн нийгмийн асуудлыг нь шийдвэрлэхэд онцгой анхаарснаар бодит үр дүнд гарсан. Энэ л алдар цуутай бригад, дивизийг захирч байх үед хамтран ажиллаж, нэгэн зорилгын төлөө хамтдаа зүтгэж явсан удирдлага, нийт бие бүрэлдэхүүн, хамт олондоо ихэд баярлаж, ямагт дурсан хүндэлж явдаг юм даа” хэмээсэн юм.

Түүнийг дээрх бригад, дивизийн захирагчаар ажиллах хугацаанд нэгтгэл, анги, салбаруудын үүрэг гүйцэтгэх чадавч, сургалт бэлтгэлийн чанар, үр дүн дээшилж, зэвсэг, техникийн ашиглалт, хадгалалт, ар тал, ахуй хангалт нь сайжирсан олон жишээг өгүүлж болох авч тэртээх жилүүдэд манай улсын төр, засгийн удирдлага, цэргийн командлалын дэмжлэг, оролцоотойгоор Сайншанд-Зүүнбаянгийн төмөр зам шинээр тавигдаж, дивизийн цэргийн нэгдсэн эмнэлэг, хороо, батальоны цэргийн байрууд, цэргийн гал тогоо, мах, ногооны зоорь, талхан цех, техникийн тавуулан болон бусад агуулахыг барьж өргөтгөх, цаашилбал орчин үеийн угсармал 60 айлын 5 орон сууцныг шинээр баруулах их ажлыг өрнүүлж, 1990-ээд оны “Зүүнбаян”-г сүндэрлүүлснийг нь түүх гэрчлэх биз ээ.

Дээр өгүүлсэнчлэн тус дивизийг зохион байгуулагдах үед захирагчаар нь томилогдсон хурандаа Т.Баатарт БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1979 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 402 дугаар тогтоолоор хошууч генерал цолыг хүртээжээ. Харин түүний дараагийн томилолт нь 1983-1985 онд Ерөнхий цэргийн 5 дугаар армийн штабын орлогч, оперативын хэлтсийн дарга, улмаар 1985-1988 онд тус армийн командлагчийн 1 дүгээр орлогч бөгөөд Армийн штабын даргаар ажилласнаар үргэлжилдэг юм. Тухайн үеийн хэрэгцээ, шаардлагаар зохион байгуулагдсан энэхүү Ерөнхий цэргийн армийн үндсэн уураг тархи нь хэмээгдсэн штабын ажлыг төлөвлөж, удирдан зохион байгуулахад тухайн албан тушаалтнаас өндөр мэдлэг, дадлага, ур чадвар шаардаж байсан нь мэдээж бөгөөд Буудлага, тактикийн курс, Ерөнхий цэргийн академи болон Зэвсэгт хүчний Жанжин штабын академийг дүүргэж,

бригад болон дивизийг командалсан хошууч генерал Т.Баатарын хувьд энэ л штабыг тун чадварлаг удирдаж, олон талт ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлсэн арвин туршлага, сургамжийг нь өнөөгийн залуус бид сайтар судалж, үйл ажиллагаандаа тусгаваас зохилтой. Ийнхүү ажил, амьдралын арвин их туршлага хуримтлуулсан хошууч генерал Т.Баатар 1988-1990 онд ЦНДС-ийн захирлын 1 дүгээр

орлогч бөгөөд Сургалтын хэлтсийн даргаар ажилласан юм. Тэр бээр “Хошууч генерал Д.Бямбацогт бид хоёрын энэхүү томилолт нь Цэргийн Нэгдсэн Дээд Сургуульд он удаан жил нэг байрандаа байж, ижил дасал болчихсон “архаг хүмүүс”-т таалагдахгүй байсан нь мэдрэгдэж байв. Биднийг очих үед сонсогчид анги дэвших, төгсөх шалгалт, шүүлгээ өгөөд эхэлсэн байв. Тавантолгойн материаллаг бааз сайтай сургалтын төвийн полигоныг ашиглан тактик, буудлага, жолоодлогын шалгалтуудыг мэргэжлийн кафедрын дарга, сургалтын хэлтсийн офицерууд болон төрөл мэргэжлийн офицеруудтай хамтран шалгаж, акт бицэж, ажилдаа шуурхайлан орч билээ. Энэ үед тус сургуулийн сургалтын төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, Дээд боловсролын хороогоор батлуулах ажлыг удирдаж байлаа. Шинэ захирал, хошууч генерал Д.Бямбацогт ажил авсан өдрөөсөө эхлээд орох хаалга, хаягаа өөрчлөн, 10 гаруй компьютертой танхимыг байгуулж, багш, сонсогчдын цайны газрыг тохижуулсны дээр нэгдүгээр курсээ бусад сонсогчдыг гадуур байрлуулах зоригтой шийдвэрийг гаргасан ба сонсогчид өглөө бүр 50 минутын багтаамжтай жагсаалын болон биеийн тамирын бэлтгэлийг хийдэг болсон. Шинэ сонсогчдыг сонгон шалгаруулж, багш, рот, курсийн дарга нарын заах аргын цугларалтыг шинэлэг хэлбэрээр зохион байгуулсан зэргээр олон бүтээлч ажлыг өрнүүлж билээ. Эрдмийн уурхай болсон энэ л сургуульд ажилласан хоёр жилийн хугацаанд мэргэжил, мэргэшлийн өндөр ур чадвартай дарга, багш, хамт олон ихэд түшиг болж, дурсамж дүүрэн байсан юм” хэмээн өгүүлэхдээ баяр баясал, бахдал бахархлын нулимс дуслуулан байсан нь нэгийг бодогдуулсан юм.

Эрхэм хошууч генерал Т.Баатарын тухайд энэ мэтээр дурсамж, бахархал дүүрэн олон арван ажлыг нь онцолж болох авч, сонины багтаамжаас шалтгаалан тун товч байдлаар өгүүлж буй минь энэ. Түүний хэлсэн “Цэрэг зэрсийнхээ мартагдашгүй он жилүүдийн дайчин алдрыг бахдан дээдэлнэм” гэсэн сэтгэлийн үгийг нь уншигч таны мэргэн оюунд толилуулах ээ.

Генералын маань эх орноо батлан хамгаалах, Зэвсэгт хүчнийг бэхжүүлэх үйл хэрэгт оруулсан хувь нэмэр, хөдөлмөр зүтгэлийг нь төр, засгаас өндөрөөр үнэлж хүртээсэн Сүхбаатарын одон, Байлдааны гавьяаны улаан тугийн одон, Байлдааны гавьяаны одон, “Алтан гадас” одон болон Зөвлөлт Холбоот Улс, Болгар, Польш, Куба улсын хүндтэй медалиуд нь түүний ажил, амжилтын арвин баялаг түүхийг өөрийн эх орондоо төдийгүй гадаадын орнууд дээд түвшинд үнэлж байсныг нотлох ажээ.

Бахдан дурсах гавьяатай, бахархах үйлсийн эзэн Баатар генералын тухайд товч өгүүлэхэд ийм буюу. Эрхэм генералдаа эрүүл энх байж, сайн үйлс бүхэн тань дэлгэрч явахын бэлгэ дэмбэрэлтийг ерөөлийг өргөн айлтгая.

Хурандаа Б.ОТГОНБАЯР



К.Е.Ворошиловын нэрэмжит академи (1976-1978) төгссөний дараа тусгай факультетын захирал, багш нарын хамт, ОХУ, Москва хот. 1978 оны 7 дугаар сар

салаатай байсан ба Армийн үлгэр жишээ үлээвэр найрал хөгжим бүрэлдэхүүнд нь багтдаг байв. Тэр үеэс энэхүү Хүндэт харуулын ротын бүрэлдэхүүн ёслолын хувцастай болж, армийн зэвсэглэлд шинээр орсон “СКС” загварын буугаар хангагдаж, төрийн болон цэргийн ёслол, хүндэтгэлийн бүхий л үйл ажиллагаанд оролцож эхэлжээ.

Тэд 1955 оны 11 дүгээр сараас эхлэн БНАГУ-ын Төрийн зөвлөлийн дарга Отто Готвальд, ЗХУ-ын Дээд зөвлөлийн дарга К.Е.Ворошилов, Дээд зөвлөлийн тэргүүлэгчдийн орлогч дарга Москатов, Сайд нарын зөвлөлийн нэгдүгээр орлогч дарга А.Микоян, БНХАУ-ын Төрийн зөвлөлийн Ерөнхий сайд Жоу Эн Лай нарын олон арван хүндэт зочдыг хүлээн авч, төрийн ёслол, хүндэтгэлийн “толь” нь болсоор ирсэн юм.

Нийтлэлийн баатар маань

авсан ба хожмоо цэргийн өндөр хариуцлагатай албыг хашихад ихээхэн нөлөө үзүүлсэн юм. Учир нь дайны гал дүрэлзсэн жилүүдэд дарийн утаа үнэртэж, фронтын галын шугамд амь өрсөн тулалдаж явсан эрэлхэг офицерууд тус сургуульд багшилдаг байлаа. Хэргийн сургалтын төвдөө дадлагын хичээлийг дайн, байлдааны бодит цагийн байдалд илүү ойртуулсан нөхцөлд түлхүү явуулдаг байсан нь биднийг “жинхэнэ” офицер болоход чухал үүрэг гүйцэтгэсэн юм” гэдгийг онцолж билээ.

Энэхүү “Цэргийн хэргийн академи”-ийн багш нарын өндөр шалгуур, шаардлагыг амжилттай давсан түүнийг 1963 оноос Улаанбаатар хотын комендатын туслахаар томилсон бөгөөд мөн л идэвх санаачилга, үр бүтээлтэй ажилласны үр дүнд Зөвлөлт Холбоот Улсын Москва хотноо

боловсрол эзэмшсэн тэр бээр 1978-1979 онд 2 дугаар мотобуудлагын бригадын захирагчаар, улмаар тус бригадыг мотобуудлагын дивиз болгон зохион байгуулахад нь дивизийн захирагчаар 1979-1983 онд ажилласан бөгөөд энэ тухайд олон арван дурсамж бий гэдгийг би бээр мэдэрч билээ.

Түүний дурсан ярьснаас “Зүүнбаянд ажиллаагүй цэргийн даргыг дарга биш хэмээдэг. Ийм үзэл бий болсон нь цаанаа учиртай. Цэргийн хүний эхний шалгуур нь халуун, хуурай говь, цөлийн уур амьсгал, нөгөө талаар байгалийн ийм хүнд нөхцөлд цэргийн сургалт бэлтгэлийг хангана гэдэг үнэхээр тэсвэр хатуужлынх нь сорилт болдгоос ингэж ойлгох нь бодит үнэн” гэснийг нь тодотгохыг хүслээ. Т.Баатар генерал цааш өгүүлэхдээ “Академиа дүүргээд ирсний дараах томилолт нь Зүүнбаянгийн бригадын

ТЭД БИДНИЙ ТУХАЙ

Тэд бидний тухай булангаараа соёл, урлаг болоод спортын алдартнуудын сэтгэлийн үсийг онцолж байна.

АМЬДРАЛД НУГАРАХААРГҮЙ НОЁН
НУРУУТАЙ БОЛГОДОГ

**"Хурд" хамтлагийн дуучин,
МУГЖ С.ТӨМӨРЦОГ:**

-Би анхны хоёр жилийн хугацаат цэргийн албыг Зүүнбаянгийн цэргийн ангид хаасан. Миний хувьд дуу хөгжимд дуртай жирийн л нэг цэрэг халагдсан ч Зүүнбаянгийн цэрэг гэж ярих дуртай. Аав, ээж маань хөдөө мал малладаг байсан учраас бага сургуульд суралцах хугацаандаа дотуур байранд амьдардаг байлаа. Багаасаа тийм амьдралд өссөн нь намайг биеэ дааж амьдрахад сургасан. Цэргийн албанд л эртнээс өөрийгөө бэлдэж байсан юм уу даа. Монголын Ардын Арми С.Төмөрцогийг шинээр төрүүлсэн учраас би их баярладаг. Монгол орны өнцөг булан бүрээс ирсэн янз бүрийн зан араншинтай залуус нэг зорилгын дор нэгдэж, атга чихэр ч байсан хувааж иддэг, тийм л нийтэч, хамтач болдог юм билээ. Цэргийн алба хүний чанарыг таниулахаас гадна хатуужил, аливааг шүүх ухаан, амьдралд нугарахааргүй ноён нуруутай болгодог. Бас их өндөр шалгуур, сахилга, зохион байгуулалттай. Эр хүний хаах л ёстой алба. Монгол Улс өөрийн гэсэн Зэвсэгт хүчинтэй байгаа нь хамгийн чухал. Энэ бол тусгаар тогтнол, халдашгүй дархан байдлын баталгаа юм. Манай хамтлагийн



хувьд олон жил цэрэг, эх орон, аав, ээжийн талаар олон уран бүтээл туурвиж, тоглолт хийж үг, үйлдлээрээ эх орондоо өргөсөн тангарагтаа үнэнчээ баталсаар яваа гэж боддог. Жишээлбэл, "Цэргийн бодол" дуу бол Арми болон энгийн иргэдийг хооронд нь хайр сэтгэлийн сэмжээр холбосон мөн манай хамтлагийг олонд таниулж өгсөн тийм л гайхалтай уран бүтээл. Тиймдээ ч одоог хүртэл дуулагдсаар байна. Бас нэг зүйлийг хэлэхэд, монгол цэргүүд маань энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэдэг

болоод багагүй хугацаа өнгөрлөө. Зүгээр ч нэг энхийг сахиулахгүй, баатарлаг үйлс байгуулсан эздээр нь манайхан л тодроод байдаг. Энэ бол бидний бахархал. Тэд улс орныхоо нэр хүндийг өндөрт өргөж яваа. Батлан хамгаалах чадвар сайжирч байгаа талаарх мэдээллийг олон талын эх сурвалжаас авч байгаа. Монгол Улсын Батлан хамгаалах яам, ЗХЖШ-ын удирдлагууд энэ тал дээр илүү ач холбогдол өгч, анхаарч ажилладагт нь талархъя.

ДҮРЭЛЗСЭН ГАЛ РУУ
ОРЖ ЧАДАХ ХҮМҮҮС

**Монгол Улсын Гавьяат
тамирчин Т.ҮЙТҮМЭН:**

-Би цэргийнхэнтэйгээ адилхан мөрдөстөн. Учир нь "Хүч" нийгэмлэгийн тамирчин байхдаа цагдаагийн байгууллагад бас ажиллаж байлаа. Ер нь Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчид маань эх орон, төр, ард түмэндээ тангараг өргөн, улс орныхоо тусгаар тогтнол, халдашгүй дархан байдлын төлөө хоёргүй сэтгэлээр зүтгэсээр ирснийг ард түмэн мэднэ дээ. Цэрэг, цагдаа гээд хэнийг нь ч харсан сэтгэл хөөрчихдөг хүн л дээ би. Эгэл биш хүмүүс шүү дээ. Дүрэлзсэн их гал руу үсрээд орж чадах л хүмүүс. Сэтгэл зүйн хувьд тийм өндөр хэмжээнд бэлтгэгдсэн гэхээр тэднийгээ хайрлаж,

хүндэлж явах учиртай. Мөн тэсвэр тэвчээр, бие бялдрын хөгжил, шийдэмгий байдал, үүрэг, хариуцлага, сахилга, зохион байгуулалт гэж юу вэ гэдгийг тод томруунаар харуулж байгаа энхийг сахиулагчдаараа бахархахгүй байхын аргагүй. Хүлээсэн үүргээрээ цэрэг, тамирчин хоёр ижил юм шиг ээ. Тусгаар тогтнол, халдашгүй дархан байдлыг бататгах гэж цэргүүд буугаа үүрдэг бол тамирчид эх орныхоо нэр хүндийг өргөхийн төлөө дэвжээнд гардаг. Ариун дагшин газар шороо, торгон хилийг минь халдашгүй дархан байлгах гэж, хойч үедээ бүрэн бүтнээр нь өвлүүлэх хүндтэй бөгөөд хариуцлагатай үүргээ цаг ямагт нэр төртэйгөөр биелүүлж ирсэн үе үеийн цэргийн алба хаагчдаа талархаад баршгүй.

ЦЭРГИЙН НӨХӨРЛӨЛ ХАМГИЙН
ҮНЭ ЦЭНТЭЙ

"Морьтон цэргийн зөвлөл"-ийн гишүүд "Ид шидийн орон-2" төслийн бүтээн байгуулалтын ажилд оролцлоо

**"Морьтон цэргийн
зөвлөл"-ийг үүсгэн
байгуулагч Х.МӨНХЖИН:**


-Бага байхад "Цэргийн сургууль" гэж олон ангит кино гардаг байлаа. Кинон дээрээс дэд түрүүч цолтой хүмүүсийг хараад би яг ийм болох сон гэж боддог байв. Ер нь цэргийн сэдэвтэй кино, ном зохиол тааралдахаар сэтгэл хөдөлдөг хүүхэд байсан даа. Анх 18 настайдаа Бээжингийн их сургуульд элсэх шалгалтад тэнцэж таван жил сурч төгссөн. Уг нь арай эрт цэрэгт явах төлөвлөгөөтэй байсан ч ээж зөвшөөрөөгүй тул сургуулиа

төгсөөд л шууд хугацаат цэргийн албанд татагдсан. Ер нь хийгээгүй харамссанаас оролдож үзээд харамссан нь дээр гэж бодогдсон учраас заавал өөрийн биеэр хугацаат цэргийн албыг хаагаад хүнд хэцүүг нь мэдэхийг хүссэн. Хийсэн сонголтдоо харамсаагүй. Харин үлдэж хоцорсон бол харамсах байсан байх. Хилийн цэргийн отрядад хуваарилагдсандаа баярладаг. Хэрвээ хотод цэргийн алба хаавал найз нөхөд маань байнга ирээд амралтын өдөр чөлөөгөөр гараад бүр дэмий. Түүний оронд яваагүй нь

дээр гэж бодоод хамгийн хол Дорнод аймагт Мэнэнгийн отрядод цэргийн алба хаах хүсэлтээ өгсөн нь өчигдөрхөн мэт санагдаж байна. Иргэний цэргийн үүргээ биелүүлж, цэргийн албаа хаахдаа торгон хилээ манаж омогших, эх орныхоо үзэсгэлэнт байгалийг тольдож, бишрэх ховорхон завшаан надад тохиосон. Тэр ч бүү хэл 25 насныхаа төрсөн өдрийг дархан хилийнхээ харуулд гарч өнгөрөөсөн нь эх орны минь надад өгсөн бэлэг гэж боддог шүү. Цэргийн нөхөрлөл хамгийн сайхан нь. Хамт наргин цэнгэж, зугаацан жаргаж байхад нөхөрлөсөн найз биш хамтдаа даарч, шөнө манаанд гарч байхад өөрийнхөө унтах цагаас хумсалж, цай чанаж аваачих нөхөрлөл надад хамгаас илүү үнэ цэнтэй санагдсан. Тэнд миний хэний хүүхэд байх нь чухал биш. Зөвхөн "чи хэн бэ?" гэдгээр л найзалж, нөхөрлөдөг. Цэргийн алба намайг тэвчээр, хариуцлага, сахилга, дэг журам, төлөвлөлт, зохион байгуулалттай болгож өгсөн. Төгсгөлд нь улс орныхоо бүрэн эрхт байдлыг баталгаажуулахад үнэтэй хувь нэмрээ оруулж буй Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын алба хаагчдаа удахгүй тохих "Монгол цэргийн өдөр"-ийн мэндийг хүргэе. Монгол цэргийн яруу алдар мандан бадраг.

ЭХ ОРОН, ЭР ЦЭРЭГ ХОЁР
ХҮЙН ХОЛБООТОЙ

**"Балдоржийн
шагналт" сэтгүүлч
Б.АЛТАНХУЯГ:**



-Би ч маруухан яруу найрагч л даа. Гэхдээ ямар ч зохиолч, яруу найрагчийн зүрхэнд цэрэг, эх орны талаар олон сайхан дөрвөн мөрт хоногшиж байдаг. Эх орон, эр цэрэг гэдэг хоёр үг яагаад ч юм салшгүй холбоотой мэт санагддаг. Эх, хүү хоёр шиг хүйн холбоотой ч байж мэднэ. Цэрэг, арми гэхээр юуны түрүүнд уншиж байсан зохиолуудын маань баатарлаг дүрүүд нүдэнд харагддаг. Тэдний талаар бичихэд онгод хөглөгддөг. Яагаад гэвэл үйлс нь ариун, үүрэг нь өндөр учраас үзэгний үзүүрээ энэ салбарынхан руу чиглүүлэхдээ үгийн сайхныг л эрж хайдаг. Бас үе үеийн ахмад дайчдыг алдаршуулмаар санагддаг. Гишгэж буй газар шороо, ундаалж буй ус, амьсгалж буй агаар бүхний төлөө тэд

амиа өргөсөн. Халхын голын байлдаан болон Чөлөөлөх дайнд оролцсон ахмад дайчид маань хоорондоо ярьж тохирсон юм шиг л ойр ойрхон цаг хугацаанд биднээс бүр мөсөн явж байна шүү дээ. Тэдний алдар, гавьяа үүрдийнх байх учиртай.

Энэ дашрамд залуусыг түүхээ судлаасай, тусгаар тогтнолын үнэ цэнийг мэдрээсэй гэж хүсмээр байна. Үйлдвэрлэлийн дадлага хийж байхдаа Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчинтэй холбоотой үйл явдлуудыг сурвалжилж явахад Төрийн хүндэт харуул жагсах тэрхэн агшинд л зурх хурдан цохилж, нисэх гэж байгаа мэт мэдрэмж төрдөг. Тийм мэдрэмжийг хэд хэдэн удаа авсан. Монгол Улсын цэргийн түүх дэлхийн түүхийн нэг хэсэг болж ирсэн. Аль эртний Хүннү гүрэн болон Чингис хааны үед л цэргийн албанд суурилсан төрийн зохион байгуулалт, засаг захиргаатай байсан нь тухайн үедээ дэлхийд байхгүй хамгийн оновчтой засаглал байсан. Ингээд бодохоор Монгол цэргийн түүхэнд гүйцэтгэсэн үүргийг хэн хэзээ ч баллуурдаж чадахгүй. Одоо Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчин улам хөгжиж олон улстай хамтын ажиллагаагаа өргөжүүлсээр байгаад иргэнийхээ хувьд баярладаг. Мэргэшсэн, чадварлаг Зэвсэгт хүчинтэй, өргөсөн тангарагтаа үнэнч цэргүүдтэй байна гэдэг эрүүл саруул, энх тунх аж төрөхийн үндэс юм.

ЦЭРГИЙНХНЭЭРЭЭ БАХАРХАЖ БАЙНА

**Жүжигчин
Ж.МӨНГӨНСҮХ:**

-Цэргийн хүмүүсийг харахаар их сайхан санагддаг шүү. Огшмоор ч юм шиг. Улсын сүр нь цэрэгтээ, цэргийн сүр нь жагсаалдаа гэж сайхан үг бий. Олуулаа жагсаад явж байгаа цэргүүд цаанаа л нэг сүрдмээр. Хийморь сэргээд л явчихна. Цэрэг нь зэрэг гэдэг үгнээс гаралтай гэж уншиж байсан юм байна. Ер нь цэргийн алба бүхнийг зэрэг эхэлж хамтдаа дуусгадгаараа онцлог байх. Тэгэхээр энэ алба ямархан өндөр шалгууртай гэдэг нь тодорхой. Нэгэн удаа

клипний зураг авалтын үеэр цэргийн ангид өнжиж байлаа. Бүтэн өдөр болсон учраас зах зухаас нь мэдэрсэн. Өглөө, өдөр, оройны нэгдэлт гээд "түм түжигнэж, бум бужигнадаг газар" байна лээ. Цэргийн амьдралд уйдаа ч зав гардаггүй юм шиг санагдсан. Би зураг авалтын зохиолын дагуу ахлах байлдагчийн мөрдөстэй хувцас өмсөж гитар тоглоод л. Гаднаа сэтгэл хөдлөлөө ил гаргаагүй боловч цэргийн хувцас надад их сайхан зохиож байсан. Тэгж анх удаа цэргийн албатай ойроос танилцсан. Ганцхан өдөр

болсон ч гэлээ энэ алба надад их дотно сэтгэгдэл төрүүлсэн. Зэвсэгт хүчинд алба хаасан, одоо хааж буй хүмүүс ёс суртахууны хувьд доголдолгүй, хэн нэгэнд итгэл найдвар төрүүлэх, түүнийгээ даах талаар хэнээс ч илүү гэж боддог. Эх оронч үзэлтэй иргэдийг бэлтгэхэд Зэвсэгт хүчин оруулсан хувь нэмэр их. Төмөр замын бүтээн байгуулалтад цэргийн алба хаагчид ажиллаж байгаа гэж сонссон. Урьд хожид байгаагүй нөр их бүтээн байгуулалтын ажлыг бас л тэд нугалж байна. Бахархаж байна.



ЦЭРГИЙН ОДОНГИЙН ҮҮСЭЛ

Аливаа улсын төр, засаг иргэдийнхээ эх орондоо байгуулсан баатарлаг үйлс, хөдөлмөр, зүтгэлийг нь өндрөөр үнэлж олон янзын хэлбэрээр урамшуулж, сайшааж ирсэн түүхэн уламжлалтай байдаг. Манай улс хувьсгалын анхны үеэс эхлэн тусгаар тогтнолын уламжлалт бэлгэдлийн зүйлсээс эх авсан одон, медаль бүхий шагналыг хэрэглэж ирсэн.

Төрийн дээд шагналыг 1913-1923 онд Богд хааны зарлигаар, 1926-1940 онд Улсын Бага Хурлын Тэргүүлэгчид ба Ардын Сайд Нарын Зөвлөлийн хамтарсан тогтоолоор, 1940 оноос Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор, 1949 оноос Улсын Их Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор, 1960 оноос Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлигаар, 1992 оноос Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар тус тус олгож ирсэн юм.

1921 онд Ардын хувьсгал ялж, Улсын анхдугаар их хурал 1924 оны 11 дүгээр сард хуралдаж анхны Үндсэн хуулийг батлан Бүгд Найрамдах Улсыг тунхагласан ба Үндсэн хуульд заасны дагуу БНМАУ-ын төрийн дээд шагнал одон, тэмдгийг бий болгох анхны ажил эхэлжээ. Энэ үеэс төрийн дээд шагнал болох одон, медалиар шагнах, алдар цол хүртээх асуудлыг 1926 онд хуралдсан Улсын III Их хурлаас баталсан Бичгийн гавьяаны одон, Цэргийн гавьяаны одонг бий болгох болон "Бичгийн гавьяаны одон шагнах тухай" гурван анги, 12 зүйлтэй дүрэм, "Цэргийн гавьяаны одон, тэмдэг шагнах тухай" дөрвөн анги, 20 зүйлтэй дүрмээр зохицуулж байжээ.

1936 оны 7 дугаар сарын 18-ны өдөр Улсын XXI хурлаар "БНМАУ-ын гавьяаны тэмдгүүдийн дүрэм"-ийг баталжээ. Уг дүрэмд нэгдүгээрт, Цэргийн гавьяаны улаан тугийн одон, хоёрдугаарт, Аж үйлдвэрийн гавьяаны улаан тугийн одон, гуравдугаарт, "Алтан гадас" одон хэмээн дэс дараа тогтоон хэрэгжүүлж эхэлсэн байна. Мөн эх орноо батлан хамгаалахад гарамгай гавьяа байгуулсан, эх орноо хөгжүүлэх, бүтээн байгуулалтын их үйлсэд гавьяа байгуулсан цэргийн хүмүүст Улсын баатар, Сүхбаатарын одон, Цэргийн гавьяаны улаан тугийн одон, Цэргийн гавьяаны одон, Цэргийн хүндэт медаль болон түүхт ойн медалиудыг төрөөс батлан гаргаж, олгож ирсэн юм.

Түүнчлэн БНМАУ-ын цэргийн дээд алдар цолтны онцгойлох тэмдэг "Маршалын од"-ыг олгодог байжээ. Улсын Бүх цэргийг захирах өрлөг жанжинд 1940, 1979 онд "Маршалын од"-ыг хоёр удаа олгосон түүхтэй.

ЦЭРГИЙН ГАВЬЯНЫ ОДОН

Цэргийн гавьяаны одонгийн эх зургийг алдарт зураач Б.Шарав, Ц.Сампилов нар зохион зурж, 1926 онд 600 ширхгийг захиалан хийлгэжээ.

Товгор улаан өнгийн паалантай таван хошуу хэлбэртэй, улаан таван хошууны хооронд алтан шаргал долоон ширхэг нарны цацрагтай, таван хошууны голд цагаан өнгийн паалантай бөөрөнхий төвгөр бамбай байна.



Цэргийн гавьяаны одон 1926 он



Цэргийн гавьяаны одон 1931 он

Бамбайн голд алтан шаргал нарыг олон зураас бүхий цацрагуудын хамт хийж, наран дээр "Соёмбо" сүлдийг товойлгон байрлуулжээ. "Соёмбо" сүлдний доорх Бадамлянхуа цэцгийн навчийг ногоон өнгийн паалангаар хийж, сүлдний хоёр талаар хос улаан тугийг өлгөсөн байдлаар дүрсэлжээ. "Соёмбо"-ын дээд талд голдоо хоёр загас бүхий жижиг улаан таван хошуутай. Загас нь улаан ба цагаан паалантай. Одонгийн улаан таван хошуу нь нэг үзүүрээс нөгөө үзүүр хүртэл 53 мм, алтан шаргал цацрагийн нэг үзүүрээс нөгөө үзүүр хүртэл 48 мм, хүндийн жин нь 32,6 грамм, эрэг боолт нь 2,6 грамм аж.

1931 оны 7 дугаар сард Ардын хувьсгалын 10 жилийн ойгоор БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 18 дугаар тогтоолоор одон тэмдгийг шагнаж явдлыг өргөтгөж, одон, тэмдгийн анхны дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулан баталжээ. Шинэ дүрэмд Цэргийн гавьяаны одонг Цэргийн гавьяаны улаан тугийн одон хэмээн нэрлэх болсон.

1926-1945 онд Цэргийн гавьяаны улаан тугийн одонг Төрийн шагналд тооцон 1941 оноос Улсын баатрын тэмдгийн хамт олгож иржээ. Энэ одон нь ард түмний дунд "Цусан гавьяаны одон" хэмээн алдаршсан билээ.

1940 оны 6 дугаар сард хуралдсан БНМАУ-ын VIII Их хурлаас баталсан Улсын шинэ сүлдийг төрийн дээд шагнал одон, тэмдэгт оруулж, одон, тэмдгийн загварт хоёр дахь том өөрчлөлт хийжээ. Цэргийн гавьяаны улаан тугийн одон нь тал тал тийш гарсан товгор үзүүр бүхий 48 мм диаметртэй, алтан цацраг дээр 39 мм-ийн хэмжээтэй улаан таван хошуутай, түүний дунд 30,5 мм-ийн диаметртэй 1940 оны БНМАУ-ын сүлдтэй. Сүлдний доод захад хоёр тийш зөрүүлсэн буу, сэлэмний дүрстэй, буу нь баруунаас зүүн тийш, сэлэм нь зүүнээс баруун тийш зөрсөн. Одонгийн доод талын тавны хоёр хувьд хийсэж буй алтан эмжээр бүхий улаан тугийн урт 45 мм, өргөн 10 мм, сүлд, сэлэм, буу зэрэг нь мөнгөлөг өнгөтэй байжээ.



Цэргийн гавьяаны одон 1940-1945 он

1940 оны Цэргийн гавьяаны улаан тугийн одон нь дөрвөн зэрэгтэй бөгөөд эх загварыг зураач Балдан, цэргийн клубийн зураач Фруценко, Улсын циркийн жүжигчин Ж.Раднаабазар нар зохиожээ.



Цэргийн гавьяаны одон 1945-1970 он



Цэргийн гавьяаны одон 1970 оноос



Цэргийн гавьяаны одон 1970 оноос

1945-1970 онд Байлдааны гавьяаны улаан тугийн одон хэмээн нэрлэгдэж байсан ба дөрвөн зэрэгтэй байв.

1960 онд батлагдсан БНМАУ-ын төрийн шинэ сүлдийг төрийн одон, тэмдэг зэрэгт байрлуулах болж томоохон өөрчлөлт хийсэн. Энэ үеэс эхлэн загвар нь өөрчлөгдөөгүй байна.

УЛСЫН БААТАР ЦОЛТНЫ ТЭМДЭГ

Монгол Улсын төрийн эрхэм дээд алдар цолыг Ардын хувьсгалын эхэн үеэс эх орныхоо төлөө эрэлхэг зориг гарган баатарлаг гавьяа байгуулсан хүмүүст олгож ирсэн.

1911-1913 онд Үндэсний эрх чөлөөний хувьсгалын төлөө баатарлаг гавьяа байгуулсан 101 хүнд Богд хааны зарлигаар "Баатар" цол, хэргэм зэрэг олгожээ. 1922-1924 онд Ардын засгийн газраас Богд хаанд уламжлан 12 хүнд "Баатар" цол олгосон байна.

БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчид ба Ардын Сайд нарын Зөвлөлийн хамтарсан хурлаас 1936 оны 2 дугаар сарын 21-ний өдөр 14 дүгээр тогтоол гарч, түүний II зүйлд заахдаа "Улсын Баатар цолыг улсын ба ард түмний төлөө дайсан этгээдүүдийг онц баатарлагаар байлдан дарж, цусан гавьяа байгуулсан хүмүүст шагнаж олгох, Үүнд: Улсын Баатар цолыг шагнахдаа Корпус командлан захирагчаас дээш албан тушаалын хүмүүст Улсын Бага Хурлаас, доош тушаалын хүмүүст Бүх Цэргийн Жанжнаас олгоно" гэжээ.

Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1936 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 4 дүгээр хурлын тогтоолоор Ш.Гонгор "Улсын Баатар" цол олгосноос хойш 1941 оны 7 дугаар сард нисгэгч Д.Дэмбэрэлд агаарын "Зоригтбаатар" цол, Халхын голын байлдаанд гарамгай гавьяа байгуулсан Ц.Олзвойд "Улсын Баатар" цол, Л.Дандарт "Гарамгай Баатар" цол олгожээ.



Улсын баатар цолтны тэмдэг 1941-1945 он

1940 оны БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчид ба Сайд нарын Зөвлөлийн тогтоолд заасны дагуу Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1941 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 43 дугаар тогтоолоор "Улсын Баатар" цол шагнаж журам, шинэ тэмдгийг баталжээ.



Улсын баатар цолтны "Алтан таван хошуу" медаль 1945 он

БНМАУ-ын Баатар цолтны тэмдэг нь алтан шар таван хошуут од байх бөгөөд зөрүүлсэн хөх паалантай таван сум хэлбэртэй байна. Алтан таван хошууны төв дунд жанжин Д.Сүхбаатарын дүрийг цагаан алтаар товойлгон дүрсэлж хийсэн. Д.Сүхбаатарын дүрийн дээд талд хагас дугуй намирсан улаан туган дээр монгол бичгээр "Баатрын тэмдэг" хэмээн бичсэн.

БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1945 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 91

тогтоолоор Улсын баатар цолтны шинэ "Алтан таван хошуу" медаль, 1946 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн 6 дугаар тогтоолоор Улсын баатар цол шагнах дүрмийг тус тус шинэчлэн баталжээ. Улсын Баатрын "Алтан таван хошуу" медалийн эх загварыг Урлагийн гавьяат зүтгэлтэн, Төрийн шагналт Д.Чойдог зохиосон байна.

Улсын Баатар цолтны "Алтан таван хошуу" медаль нь таван хошуутай, нэг хошуу нь гурван талст бүхий цацраг үзүүртэй, хошууны хоорондох завсарт буюу таван буланд дугуйрсан гурван цацраг дэвсгэр дээр бөөрөнхий Очир алмаазан шигтгээтэй, дээд сууринд ар талдаа хувцсанд тогтоох зүүтэй хийгджээ.

Улсын баатар цол шагнуулсан хүнд Сүхбаатарын одон, баатрын "Алтан таван хошуу" медалийг үнэмлэхийн хамт олгож ирсэн түүхтэй.

1936-2020 он хүртэл Монгол Улсын төрийн эрхэм дээд алдар цолыг нийт 59 хүнд олгоод байна.

МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ДЭЭД ШАГНАЛ

Дэлхийн II дайн дуусаж, Монгол-Зөвлөлтийн армийн их ялалтыг тохиолдуулан БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдээс төрийн дээд шагнал болон Сүхбаатарын одонг 1945 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 78, 79 дүгээр тогтоолоор батлан гаргасан.

Сүхбаатарын одон бол төрийн хамгийн дээд шагнал бөгөөд төр, батлан хамгаалах, эдийн засаг, аж ахуй, соёл, урлаг, боловсролын салбаруудад гарамгай гавьяа байгуулсан иргэд болон байгууллага, цэргийн анги, нэгтгэл, аж үйлдвэрийн газруудыг шагнахаар заажээ.

Сүхбаатарын одонг алтан таван хошуу бүхий хааш хаашаа 50 мм давхарлаг тунгалаг тэнгэрийн өнгөт хөх цэнхэр цацраг бүхий паалангаар үйлдэнэ. Төв дунд нь жанжин Д.Сүхбаатарын дүрийг 20 мм-ийн диаметртэй дугараг товойлгосон алтан хүрээний дотор бор хүрэн өнгийн дэвсгэр дээр цагаан алтаар товойлгон үйлдэж, дээр нь баруунаас зүүн тийш нугаларсан 2 цацаг бүхий улаан тугийг хийсэн байна. Улаан туг нь алтан хүрээтэй өргөн нь 7 мм, доор нь 6 мм диаметр хэмжээтэй жижиг таван хошууг алтаар товойлгон хийсэн Бадамлянхуа цэцгээр хүрээлсэн. Улаан туган дээр алтаар "Сүхбаатар" гэж бичсэн байна.



Сүхбаатарын одон 1945 он

Улсын баатар болон Хөдөлмөрийн баатар цолтонд баатрын тэмдгийн хамт Сүхбаатарын одон шагнадаг.

БАЙЛДААНЫ ГАВЬЯНЫ ОДОН

БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1945 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 91



Байлдааны гавьяаны одон 1945-1970 он



Цэргийн гавьяаны одон 1970 оноос

дүгээр тогтоолоор Байлдааны гавьяаны одонг шинээр буй болгон уг одонгийн загвар, дүрэм, тодорхойлолтыг баталжээ.

Цэргийн гавьяаны одон нь таван хошуу хэлбэрийн дэвсгэртэй, алтан шар эмжээр, судалтай цагаан паалантай уртлаг навч хэлбэрт цацрагтай, төв дундаа сүлдтэй, сүлдний доод талд зөрүүлж хийсэн буу, сэлэмтэй.

Одонгийн эх загварыг Урлагийн гавьяат зүтгэлтэн, Төрийн шагналт Д.Чойдог зохиожээ.

МАРШАЛЫН ОД

Энэ нь улс орны Зэвсэгт хүчний дээд ерөнхий командлагч, Маршал, Флотын Адмирал зэрэг цэргийн дээд албан тушаалтан, дээд захирагч, командлагч, жанжин нарт олгогдож ирсэн ялгаж тэмдэг юм. Европын олон улсын армид XVII зуунаас цэргийн дээд захирагч жанжин нарт Маршалын од, очир зүүлгэдэг болсон түүхтэй. Маршалын од, очир нь Маршал цолтны онцлох тэмдэг бөгөөд эрхэм дээд хүндэтгэлийн титэм болж иржээ.

БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1944 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн тогтоолоор БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга, ЦЯЯ-ны сайд,



Маршалын од 1944 он

МАХЦ-ийн Бүх цэргийн жанжин Х.Чойбалсанд Маршал цолтны онцгойлох тэмдэг "Маршалын од"-ыг анх олгосон.

Маршалын од нь товгор хэлбэртэй нарны туяа тал бүр тийшээгээ 108 ширхэг цацарсан байдалтай, төв дунд нь 1940 оны сүлдийг цагаан алтаар хүрээлэн байрлуулсан, сүлдийг тойрсон таван хошуунд улаан бадмаараг шигтгэж, таван хошуу, таван талстыг алмазаар хүрээлсэн байдаг. Маршалын одны дээд үзүүрт зүүлтний бэхлэгээр байрлуулсан байх бөгөөд хүзүүнд зүүх шар хүрээтэй, улаан торгон өргөн бүчтэй байна.

Маршалын одны эх загварыг Урлагийн гавьяат зүтгэлтэн, Төрийн шагналт Д.Чойдог зохиожээ.



Маршалын од 1979 он

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1979 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн зарлигаар МАХН-ын Төв Хорооны I нарийн бичгийн дарга, Армийн генерал Ю.Цэдэнбалд цэргийн дээд цол болох БНМАУ-ын Маршал цол олгожээ.

Ю.Цэдэнбалд олгосон Маршалын од нь шижир алтаар төвийлгөн хийсэн тал бүр тийшээ туяа цацарсан хэлбэртэй алтан таван хошуу байв. Таван хошууны гол дунд цагаан алтаар товойлгож хийсэн төрийн сүлдийг байрлуулсан байна. Одны хошуунуудын хооронд таван ширхэг алмазыг цагаан алтаар хүрээлүүлж шигтгэсэн. Маршалын од нь алтан бэхлэгээр гурвалжин алтан сэжктэй холбогдож, түүнээс төрийн далбааны өнгөтэй торгон туузаар сүвлэсэн байна.

Монгол цэргийн музейн Эрдэм шинжилгээний ажилтан-түүхч Ж.ОДОНТУЯА

СТАНДАРТЧИЛАЛ БА СТАНДАРТЫН ҮНДСҮҮД

(Түрүүч нь №09 дэх дугаарт)

Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний стандартчилал ба стандартын мэдлэгийг дээшлүүлэх зорилтыг хэрэгжүүлэхээр “Соёмбо” сониноор цуврал нийтлэлийг хургэж байгаа нь энэ.

ГУРАВ. СТАНДАРТЧИЛЛЫН ҮНДСЭН АРГУУД

Радиоэлектроникын стандартчиллын үндсэн аргуудад зохимжтой тооны арга, ижилтгэх арга, орлуулах арга, хязгаарлах арга болон загварчлах аргууд багтааг.

1. Зохимжтой тооны арга

Стандартчиллын хэмжээ ба үзүүлэлтийн системд нэгдсэн зүй тогтол нь стандартчиллын аргыг тогтоох дискрет утгын нийлбэр/зохимжтой тооны дараалал/-ээр тодорхойлогддог. Энэ системийн гол санаа нь тодорхой нэг математикийн хуульд хатуу захирагддаг хэмжээ ба үзүүлэлтийг сонгоход оршино.

Зохимжтой тооны хэрэглээ нь хэсэгчилсэн болон бүлэг бүтээгдэхүүн, тэдгээртэй холбогдох бүтээгдэхүүний бүх төрөл, зүйлийн хэмжээ ба үзүүлэлтийн боломжит зөвшилцлийг хангадаг. Энэ нь энерги, эд материалыг хэмнэлттэй зарцуулахад түлхэц болдог.

Зохимжтой тоон дарааллын шаардлага:

-Ашиглалт ба үйлдвэрлэлийн шаардлагад нийцсэн тооны шатлалын оновчтой системийг үзүүлэх;

-жижиг болон том хэмжигдэхүүний аль ч талд хязгааргүй байх, өөрөөр бол хэмжээ эсвэл үзүүлэлтүүдийн хязгааргүй хөгжлийг зөвшөөрөх;

-энгийн, тогтооход хялбар байх;

-нэг болон дурын тооны 10 зэрэгт дэвшүүлсэн утгыг багтаах;

-стандартчилалд арифметик болон геометр прогрессоор бүтээгдсэн зохимжтой тоон дараалал ашиглагдаж эхэлсэн.

2. Ижилтгэх арга

Өргөн хэрэглээний шинэ бүтээгдэхүүн бий болгох эсвэл тэдгээрийг шилж, сонгох замаар одоо хэрэглэгдэж буй бүтээгдэхүүний нэршлийг оновчтойгоор багасгахад чиглэсэн стандартчиллын арга юм.

Ижилтгэх аргын шинж тэмдгүүд:

-бүтээгдэхүүний хийгдсэн байдал нь ижил төрлийнх байх;

-бүтээгдэхүүний ажиллагаа бүрэн төгс байх;

-бүтээгдэхүүний үндсэн үзүүлэлтүүд нь үндсэн шаардлагаг хангадаг байх;

-төрөл бүрийн байгууламжийн эсвэл үйл ажиллагааны зориулалтын системийн бүрэлдэхүүнд ижилтгэсэн бүтээгдэхүүнийг ашиглах боломжтой байх;

-ижилтгэх нь байгууламжийн зэрэг эсвэл бүтэн бүлгийн хэмжээнд бүтээгдэхүүний төрлийн тоог багасгахад хүргэнэ.

3. Орлуулах арга

Бүрэлдэхүүн хэсгүүд нь ажиллагааны эсвэл хэмжээний хувьд харилцан нэгнээ -бүтээгдэхүүн дээр үндэслэсэн тусгай ажиллагааны зориулалттай бүтээгдэхүүн бүтээхэд чиглэгдсэн стандартчиллын арга юм.

Орлуулах аргын шинж тэмдгүүд:

-Бүрэлдэхүүний зангилаа, механизм болон тусдаа эд ангиудын ажиллагааны бүрэн төгс байдал;

-Бүрэлдэхүүн хэсэгт багтах агрегатын дахин ашиглах боломж, бүтээцийн хуучин хэвэндээ орох чанар;

-бүрэлдэхүүн хэсэгт багтах агрегатыг өөрчилж тавих үед бүтээгдэхүүний ажиллагааны шинж чанарын өөрчлөлт.

Ижилтгэх ба орлуулах аргуудын хооронд олон ижил зүйлс байдаг боловч зарчмын ялгаатай зүйлс бас байдаг. Хэрэв орлуулах арга нь тусгай ажиллагааны зориулалттай бүтээгдэхүүнийг бүтээхээр байдаг бол ижилтгэх арга нь тусгай ажиллагаатай бүтээгдэхүүн эсвэл жинхэнэ бүтээгдэхүүний суурин дээр өргөн хэрэглэгдэх бүтээгдэхүүнийг бүтээхэд чиглэгдсэн байдаг.

4. Хязгаарлах арга

Ямар нэг бүтээгдэхүүн эсвэл тухайн салбар, үйлдвэрт ашиглахыг зөвшөөрөгдсөн бүтээгдэхүүний нэршлийг оновчтой хязгаарлах, одоо байгаа бүтээгдэхүүний нэгдлээс ялгаж авахад чиглэгдсэн стандартчиллын арга юм.

Хязгаарлах аргыг ямар ч түвшинд явуулах боломжтой. Тухайлбал, улсын стандартуудыг салбарын хэмжээнд хязгаарлах, харин салбарын стандартуудыг үйлдвэр, байгууллагын түвшинд хязгаарлах болно. Хязгаарлах арга нь стандартчиллын хамгийн энгийн арга боловч маш том техник, эдийн засгийн идэвхтэй байдлаар тодорхойлогдоно.

5. Загварчлах арга

Ажиллагааны зориулалтын хувьд адил эсвэл ойролцоо өөр бүтээгдэхүүнүүдийг бүтээх үед суурь бүтээгдэхүүний нэгдэлд тооцогдох бүтээгдэхүүний ихэнх ажлыг гүйцэтгэдэг зарим нэг загварыг тогтоох замаар бүтээгдэхүүний төрлийг оновчтойгоор багасгахад чиглэгдсэн стандартчиллын арга юм.

Радио электроник загварчлах аргын суурин дээр олон янзын хэрэгслийг зохион бүтээхэд болон загварын блокуудыг ашиглан төрөл бүрийн төхөөрөмжийн төслийг боловсруулахад өргөнөөр хэрэглэгдэж байна. Орчин үеийн үйлдвэрлэлийн хөгжлийн үе шатанд улс төр, эдийн засгийн нэг чухал үүрэг нь бүтээгдэхүүний чанарыг сайжруулах явдал болж байна. Энэхүү үүргийг биелүүлэхэд стандартчиллын аргуудыг зөв хэрэглэн төрөл бүрийн зориулалтын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн төслийг практикт нэвтрүүлж өргөнөөр ашиглахаас хамаарна.

ДӨРӨВ. МОНГОЛ УЛСЫН

СТАНДАРТЧИЛЛЫН ҮНДСЭЛЭЛ

4.1. Стандарт ба стандартчиллын хууль, эрх зүйн орчин:

- Үндсэн хууль;
- Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль;
- Хэмжил зүйн тухай хууль;
- Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль;
- Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль;
- Салбарын бусад хуулиуд;
- Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, шийдвэрүүд;

- Үндэсний чанарын хөтөлбөр;
- Үндэсний итгэмжлэлийн төвийн дүрэм;
- Аюулгүйн тэмдгийн хэлбэр, хэмжээ, хэрэглэх журам;
- Техникийн зохицуулалт боловсруулах заавар;
- Техникийн зохицуулалтын төсөлд шүүлт хийх журам.

Монгол Улсын стандартчиллын зохион байгуулалтын үндэс нь Улсын Их Хурлаар 2018 онд батлагдсан “Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний, итгэмжлэлийн тухай хууль”, “Монгол Улсын үндэсний стандартчиллын тогтолцоо” “MNS 1-1:2006 Техникийн ажлын журам”, “MNS 1-2:2006 Стандартын бүтэц ба боловсруулах дүрэм” зэрэг суурь стандартууд болно.

Монгол Улсын Засгийн газар, Стандарт, хэмжил зүйн газар, төрийн байгууллага, төрийн бүс байгууллага, бизнесийн байгууллага, үйлдвэрлэгч, хэрэглэгч болон аймаг, орон нутгийн Стандарт, хэмжил зүйн газрууд, стандартчилал, хэмжил зүйн үйл ажиллагааг зохион байгуулан хэрэгжүүлнэ.

4.2 Улсын стандартын үүрэг:

- Улсын хэмжээнд стандартчилал ба хэмжил зүйн нэгдсэн техникийн бодлого хэрэгжүүлэх;
- Шинжлэх ухааны үндэслэлтэй хэмжлийн арга болон бүтээгдэхүүний чанарын үндсэн асуудлыг боловсруулах;

➢ Стандартчилал, хэмжил зүйн аргууд /ижилтгэх, орлуулах, загварчлах, хязгаарлах/-д үндэслэн техник, эдийн засгийн болон шинжлэх ухааны арга зүйн үндсэн чиглэлийг тодорхойлон хөгжүүлэх;

➢ Нэн шаардлагатай улсын стандартуудыг боловсруулж мөрдүүлэх;

➢ Хэмжих техникийн ашиглалт, чанар байдал болон стандартыг сахин мөрдөж байгаад Улсын хяналт шалгалт явуулах;

➢ Стандартчилал, хэмжил зүйн хүрээнд бүтээгдэхүүний чанарыг сайжруулсан амжилт, шинжлэх ухаан, техникийн ололтын тухай мэдээллийг сурталчлах.

Монгол Улсад төрийн байгууллага, бизнесийн байгууллага, хувийн хэвшил, үйлдвэрлэгч, хэрэглэгчийг хамарсан стандартчиллын нэгдсэн системийн стандартууд хэрэглэгдэж байна.

4.3. Монгол Улсын стандартчиллын нэгдсэн систем

01. Нийтлэг зүйл, нэр томъёо, стандартчилал, баримт бичиг;

- 01.020 Нэр томъёо (зарчим, зохицуулалт);
- 01.040 Тайлбар толь;
- 01.060 Хэмжигдэхүүн ба нэгж;
- 01.070 Өнгөөр кодчилох;
- 01.075 Үсгэн тэмдэг;
- 03. Үйлчилгээ, компанийн зохион байгуулалт, менежмент ба чанар, захиргаа, тээвэр, зориулалт;
- 03.100 Компанийн зохион байгуулалт, менежмент;
- 03.200 Чөлөөт цаг, аялал жуулчлал;
- 03.220 Тээвэр;
- 03.240 Шуудангийн үйлчилгээ;
- 11. Эмнэлгийн тусламжийн технологи;

- 11.020 Эрүүл мэндийн шинжлэх ухаан ба эмнэлгийн тусламжийн нийтлэг асуудал;
- 11.040 Эмнэлгийн тоног төхөөрөмж;
- 11.060 Шүд;
- 11.080 Ариутгал, халдваргүйжүүлэлт;
- 11.100 Эмнэлгийн лаборатори гэх мэт. Монгол Улсад 2019 оны байдлаар үндэсний 4290 стандарт мөрдөгдөж байна.

ТАВ. ОЛОН УЛСЫН СТАНДАРТЧИЛЛЫН БАЙГУУЛЛАГА

1.ISO-Олон улсын стандартчиллын байгууллага-(ОУСБ)

- 1946 онд байгуулагдсан;
- 164 орон гишүүнээр элссэн;
- 250 техникийн хороо, дэд хороотой;
- 22808 стандарт гаргасан;
- Стандартын хамрах хүрээ нь: Худалдаа, эдийн засаг, техник, шинжлэх ухаан, тохирлын үнэлгээ;
- 1979 онд Монгол Улс /Стандарт, хэмжил зүйн газар/ гишүүнээр элссэн;
- ISO-ийн 1268 стандартыг Монгол Улсын стандарт болгосон.

2.IEC-Олон улсын цахилгаан техникийн комисс-(ОУЦТК)

- 1906 онд байгуулагдсан;
- 86 орон гишүүнтэй;
- 87 түншлэгч байгууллагатай;
- 104 техникийн хороотой;
- 10770 стандарт гаргасан;
- Стандартын хамрах хүрээ нь: Цахилгаан техник, электроник, тохирлын үнэлгээ;
- 2001 онд Монгол Улс гишүүнээр элссэн;
- IEC-ийн 104 стандартыг Монгол Улсын стандарт болгосон.

3.ITU-T-Олон улсын цахилгаан холбооны байгууллага-(ОУЦХБ)

- 1865 онд байгуулагдсан;
- 99 орон гишүүнээр элссэн;
- 100 гишүүн компанитай;
- 150 стандарт, зөвлөмж гаргасан;
- Стандартын хамрах хүрээ нь: Цахилгаан холбоо, радио холбоо;
- 1961 онд Монгол Улс гишүүнээр элссэн;
- Монгол Улсын үүрэн холбооны хэрэглэгчид-4,3 сая /2019 он/;
- Монгол Улсын шилэн кабелийн сүлжээ-43,4 мян.км/2019 он/.

Олон улсын цахилгаан холбооны байгууллагын үүрэг:

➢ Дэлхийн хүмүүстэй хаана амьдардаг, мэдлэг боловсрол, баян, ядуугаас үл хамааран холбогдон нэгтгэх;

➢ Дэлхийн хүмүүстэй харилцах эрхийг дэмжих, хамгаалахад оршино.

Монгол Улсад 2019 оны байдлаар олон улсын 2109 стандартыг үндэсний болгон хэрэглэж байна.

Стандартчилал ба стандартын үндсүүд цуврал нийтлэлийг нийтэлж Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний мэдлэгийг дээшлүүлэхэд хамтран ажилласан “Соёмбо” сонины редакцын хамт олонд гүн талархал илэрхийлье.

Бэлтгэл хурандаа Ц.ДОРЖХҮҮ

Захидал задлахуй дор

САЙН БАЙНА УУ? ЭЭЖЭЭ

Таны төрүүлж өсгөсөн үр нь тандаа захидал бичиж сууна.

Ээжээ, намрын зузаан өрмөөр бурамтай чихэр сольж өгсөнгүй гэж уурлаад л, цас орж хүйт даасан өдрөөр үнээнд хамт явъя гэж таныг зовоогоод л цэцэрлэгт яваагүй, сумын төв ч орж үзээгүй миний амьдралын долоон жил тантай хамт өнгөрсөн. Айлын хүүхдүүд өнгө өнгийн тоглоомоор тоглож байхад харин би эрээн авдрынхаа нүүрийг халцартал бөглөө давтаж тоглоод л танд загнуулдаг сан. Дүнсэн тамхины цагаан цаасан дээр “А” үсэг бичээд л, аминдаа хичээл хийдэг байсан байх даа.

Дарайсан саальтай хүнд дээлтэй хэр нь намайг үүрчхээд явахдаа та огт түүртдэггүй, даврааж харин хааяахан ирдэг машинтай наймаанаас эрээн өмд авч өгөн гангалж намайг юугаар ч дутаагаагүй өсгөсөн дөө. Сургуульд ороод би харин сумын төвдөө төөрч будилсан шүү ээж ээ. Гэхдээ би танан цагаан гэртээ тараг сүүнд холбирч, хяруу унасан цэцгэн дээгүүр хөл нүцгэн гүйж явахдаа таны хайртай хамт цэцэрлэгийн боловсролыг авсан юм байна лээ.

Таныгаа амьдад нь баярлуулж чадаагүй ч одоо би тангараг өргөсөн цэргийн бүсгүй болсон. Ээж ээ би бүр даян дэлхийн амар тайвныг хамгаалах үйлсэд олон залуустай мөр зэрэгцэн зүтгэж явна. Ээж ээ, та намайг дэндүү эрт орхисон ч миний энд үүрэг гүйцэтгэж байгаа нь таны минь ач юм шүү. Та намайг очиход сүү амсуулаад хацрыг минь үнсээд тосоод авдаг бол мөн сайхан аа. Ээж ээ, төрж, үхэх хоёртой хүн бүр л тулгардаг болохоор орхиод явлаа гэж гомддоггүй ээ. Зүгээр л дэндүү эрт явчаж дээ гэж харамсдаг юм. Хааяа шантрах, гомдох, туних ээлжлэх л юм. Гэхдээ би дэлгэр зунаар хөлийнхөө тавхайг шир шиг болгочоод гүйн явсан үеэ бодон тайтгардаг юм. Тантай өнгөрүүлсэн долоон жил хамгийн богинохон ч үнэхээр жаргалтай мөчүүд байж дээ. Ээж ээ та энэ захиаг уншихгүй ч зүрх сэтгэлд минь дандаа хамт байдаг юм шүү.

Өдөр тутамд хэлдэггүй ч

Өнө мөнхөд бодож явдаг үгээ

Өнөөдөр л амжиж хэлье

Ээж ээ би танд хайртай

Бүдэг бадаг орчлонг гэрэлтүүлж

Бүүвэйн дуу сонссон болохоор

Бүтэн биеийг минь төрүүлж өсгөсөн

Бурхан ээжийгээ санаж бичлээ

Найр хайрын орчлонд

Намайг бас чамайг төрүүлсэн ээждээ

Нартад мэндэлсэн үр нь чи болохоор

Насан эцэс болохоос нь өмнө очиж

үнсүүлээрэй

Хожим чи харамсахгүйн тулд

Хорвоод тээж төрүүлсэн ачийг нь санаарай

Чиний төлөө миний төлөө

Чихээ дэлдгийлгэж нүдээ бүлтийтэл

хүлээдэг юм шүү

Хоног хоногор над руу урсах ээжийнхээ

Хэзээ ч тасрахааргүй үр нь би болохоор

Таны сэтгэлээс хайр нэхэж нялхрахдаа

Талын цэцгийн шүүдрээр мөнгөн дэвсгэр

хийдэг юм шүү

Алдаж одсон он жилүүддээ эргээд нэг

очих сон

Алгаа тосоод бороон дундуур эцтэлээ

нэг гүйхсэн

Ааруул нууцхан хулгайлчхаад ээждээ дахин

зэмлүүлэхсэн

Айлын хүүхдэд шоглуулчхаад аавдаа

нэг аргадуулахсан

Зөрүүд бага насны минь алдааг

та л уучилдаг

Зүсээ гундтал та минь л надад санаа зовдог

Зөөлөн шаргал хайраар та минь л намайг

жаргаадаг

Зөндөө их хайраар та минь л намайг

хайрладаг

Амьд бурхан ижийдээ л нэг очиж

үнсүүлээрэй

Энэ хорвоо ертөнц дээр

Ээжийн чанасан цай шиг тансаг амттан

гэж байдаггүй юм

Энэ хорвоо дэлхий дээр

Ээжийн тань өгсөн хайр шиг агуу их

жаргал байдаггүй юм

Дэд ахлагч Д.ОЮУН-ЭРДЭНЭ

/Зэвсэгт хүчний 327 дугаар анги/

Афганистан улс, Мазар-И Шариф хот,

Мармал бааз.

2020 оны 3 дугаар сарын 3-ны өдөр

ЦАЦАЛ ХҮРЭХ ЦАРИГ ЦАГААН ТЭНГЭРТ ХАЯГЛАХУЙ

Сэтгэлд минь нар шиг мандаж, зүрхэнд үүрд хамт орших сайхан бүхний эхлэл санчигтаа өнчин хяруугүй, ануухан ижий минь та энх мөнх сууна уу? Ивлэсэн сүүний тань дусал бүр цээжинд амтагдаж, эрхлүүлж аргадсан үг бүр тань зүрхэнд зүсэрч охин нь таныгаа мөн ч их санах юм даа. Та минь охиноосоо буцаад олон намар, олон хаврыг үджээ.

Жил бүрийн 11 дүгээр сарын 4-ний өдөр тандаа захидал бичин Таныгаа санасан сэтгэлээ бага ч болов тайтгаруулдаг юм. Энэ өдөр Та минь орчлонд гэгээ татуулан мэндэлсэн юм шүү дээ. Хэзэний л Та минь төрсөн өдрөө мартчихсан явдаг байж билээ. Ээжгүй амьдралын уйтгай гашууныг эрх дураараа жаахан охин чинь энэхэн зүрхээрээ эмтрэн туулж явна. Та минь охин үрийнхээ сэтгэлийн хамгийн том, хатан орон зай билээ. Эх дэлхийнхээ нүүрэн тал Африк тивийн Өмнөд Судан улсаас Тандаа захидал бичин холын шувуудад дайх ховорхон боломж надад тохиолоо. Энд охин нь мөрдэс нэгт дайчин нөхөдтэйгөө мөр зэрэгцэн “Энхийг сахиулагч” хэмээх эрхэм алдрыг бат өргөн Монгол Төрийнхөө Алтан соёмбот далбаан дор ёслон зогсож байна. Ээж, аав Та хоёр минь харсан бол эрх жаахан охиноо магтан, нар үнэртсэн духыг минь үнэрлэн бахархан зогсох байсан нь лавтай. Олон бяцхан нялхсыг эх барьж, амьдрал бэлэглэсэн эгнэшгүй ачтан нь Та атал, одоо харин яагаад үрийнхээ дэргэд байхгүй байгаа юм бэ гэж бодохоор хорвоогийн хатууд гомдмоор, цурхиртал уйлмаар, юутай уйтгай. Та минь охиндоо өөрт байсан сайхан бүхнээ дээжлэн үлдээжээ. Уучлах уужим сэтгэл, хайрлах халуун зүрх, дэмжиж туслах хүнлэг чанар, дэм дэмэндээ амьдрах нийтэч зан гээд хүн бэхийн учир утгыг би Танаасаа өвлөсөн билээ. Үүнээс илүү эрхэм бэлэг, нандин баялаг гэж юу байх сан билээ. Та минь мөн ч нугаршгүй зоригтой, дайчин эмэгтэй байжээ. Одоо охин нь хүний гэргий, дөрвөн сайхан үрийн ээж болж, амьдралын жаргал зовлон, баяр хөөр, уйтгар гуниг ээлжилсэн он жилүүдийн нугачаанд Таныгаа дэндүү ихээр ойлгож, улам бүр хайр, хүндлэл булгилан оргилох юм. Хамгийн аугаа эрдэмтэн, багш, сэтгэл зүйч, анагаагч

шидтэн, халамжлан хамгаалагч, үлгэр дуурайлын дээд, үзэсгэлэн төгөлдрийн оргил нь Та минь байжээ. Намайг хатуу үгээр зэмлэж байсныг чинь охин нь ер санадаггүй юм. Та минь намайгаа дэндүү эрх танхил өсгөжээ. Зүйл бүрээр намайг дэмжин урамшуулж, “би чадна” гэсэн мохо

Монголын Зохиолчдын Эвлэлийн шагналт зохиолч, сэтгүүлч, яруу найрагч, бэлтгэл дэд хурандаа Гомбын Баатарнум 1957 онд Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын нутаг "Харваах" гэдэг газар төржээ. Цэргийн зохиолчдын хуруу дарам цөөн төлөөллийн нэг тэр бээр ЦЕДС, УТИС, Хэвлэл мэдээллийн "Зохиомж" дээд сургуулийг тус тус дүүргэжээ. Багаасаа зурж, бичих сонирхолтой тэр тухайн үеийн УБДС-ийн Монгол хэл, уран зохиолын ангид элссэн ч хувь

төөрөг нь цэрэг, армийн амьдрал байв. Хөдөөгийн анги, салбарт олон жил ажиллаж, бичгийн ажлаас хол хөндий байсан ч багын мөрөөдөл нь дахин "гижигдэж", 1980-аад оноос утга зохиол, сэтгүүл зүйн ертөнцөд эргэлт буцалтгүйгээр хөл тавьж, "Нийслэлийн сонин бичиг", "Чөлөөт хөдөлмөр", "Улаанбаатар", "Улаанбаатар таймс", "Соёмбо" зэрэг сонин хэвлэлийн газар олон жил сурвалжлагч, ахлах сурвалжлагчаар ажиллахдаа "Жүжигчид ээ гэж ...", "Урт хэл",

"Сэтгэлийн өргөл", Хувцрахын үедис", "Орлой гурван зээр", "Иракаас бичсэн тэмдэглэл" зэрэг 10 гаруй ном, "Босоо төрсөн хүлэг", "Зүүдэнд тодрох ээж минь", "Бодолд уяатай аав минь", "Энхийн үйлсэд монгол цэргүүд", "Сэтгэлд хургасан Дарьганга нутаг" зэрэг 100 гаруй дуу, "Алмастай нөхцсөн нь", "Иракт өнгөрүүлсэн 190 хоног", "Цэнхэр дуулгатны жимээр" уран сайхны болон баримтат кино бүтээжээ. Түүний сүүлийн жилүүдэд бичсэн шүлгээс толилуулж байна.

АЛТАН ОВОО-АМИН ШҮТЭЭН

Алтан Овоо Та
Амин шүтээн минь билээ!
Ар, Өвөр Монголдоо ч
Алдар нь түгсэн адислал билээ!
Болохгүй, бүтэхгүй бүхнийг
Болгоож хэлтрүүлдэг шидтэн Та!
Бороо хурыг намируулдаг
Бурхны бүрэлбаатай шидтэн Та!
Сэтэртэй цагаан хүлэг нь
Шилийн энгэрт тааваараа идээшилнэ
Итгэлтэй олон түмэн
Энд тэндээс хурна
Хэдэн зууны тэртээ
Оргилж буцалсан галт уул аа!
Хэдэн үеэрээ тахиж ирсэн
Миний нутгийн Хан уул аа!
Оройд нь гараад харахад
Онгоцонд суусан ч юм шиг ээ!
Оорог бор толгод нь
Тэнгэрийн хаяатай ханьссан ч юм шиг ээ!
Ганга нуураа тольдон
Живаа жилийг элээсэн
Гангар хунгаа зэллүүлэн
Сансарт асарлан дүнхийсэн
Алтан Овоо Та
Арван зүгтээ дэлгэрсэн
Буян уул аа!
Алтан Овоо Та
Алтан дэлхийдээ мөнхөрсөн
Хүн уул аа!
Ум маха дэва уба сэга сарва сэди за!

Үндэсний цэцэрлэгт хүрээлэн,
2020 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр



МИНИЙ МОНГОЛЫН САЙХАН

Аавын сургаал асарлах уулс шиг сайхан
Адуу мал тайван бэлчих сайхан
Бороо шивэрч, газар чийглэх сайхан
Болжмор жиргэж, шувууд ганганах сайхан
Вандан аваргын тухай домог хуучлах сайхан
Ваартай цэцэг гөлөглөн ургах сайхан
Гүүн зэлэнд бүсгүй гурайлах сайхан
Гүйгүүл морь холоос ирэх сайхан
Дорно зүгээс наран мандах сайхан
Домботой айраг аажуухан исэх сайхан
Ерөнхийлөгч Монголын аав байх сайхан
Ертөнцийг таних ном эрдэм сайхан
Ёочин хөгжим уянгалан эгшиглэх сайхан
Ёохор хатирч, цэнгэн баясах сайхан
Жанжин тугаа намируулан алхах сайхан
Жаргалын найман морь хойморт байх сайхан
Зүрхэн уулын тагтад сарлаг тоших сайхан
Зүлэг ногоо халиуран найгах сайхан
Идээшиж дассан нутгаа дурсан санах сайхан
Ингэн туйлаадас будран хаялах сайхан
"Калинка"-г амилуулсан Дорждэрэм дуулах сайхан
"Канны"-н наадамд уригдан залагдах сайхан
Лувсан гавьяат дэлгэцнээ тодрох сайхан
Лус сахиусаа аргадан, уул усаа шүншиглэх сайхан
Манан татаж, будан суунаглах сайхан
Манцуйтай хүүхэд үнэгчлэн нойрсох сайхан
Номхон бор моринд навтгар хүү зүүгдэх сайхан
Ноёлог шовх оргилд янгир дүүлэх сайхан
Оюутан залуус урагш тэмүүлэх сайхан
Орон улсаа дэвжээн хөгжүүлэх сайхан
Өндөр дээрээс орчноо хараачлах сайхан
Өргөн хөндийд үнэг шогших сайхан
Пүрэвдорж найрагчийн "Тусгаар тогтнол" сайхан
Пүрэвсүрэн зохиолчийн "Их тээлийн даваа" ч сайхан
Рашаан булгийн усаа амтлан ундаалах сайхан
Радиоогоор ардын дуу сонсох сайхан
Сэргэлэн дэнжид ханаа дугуйлах сайхан
Сэдэд агай цоохор морио панзлах сайхан
Тэмээн тэрэг хөтөл даван наашлах сайхан
Тэнгэр дуугарч, цахилгаан цахилах сайхан
Уурга барьсан адуучин мориндоо мордох сайхан
Уудам талаар салхи исгэрүүлэн давжих сайхан
Үлгэрч өвөө тууль хайлах сайхан
Үнээ, тугал зөөлөн хивэх сайхан
Физик, математикийн ухаанд шамдан суралцах сайхан
Философилог сэтгэлгээг хүн бүр эзэмших сайхан
Хээр хоносон сар мэлтийн гийх сайхан
Хэсэг зээр тоос манарган давжих сайхан
Цагаан сар анирдан чимээлэх сайхан
Цантай өвлийн жаварт хацраа хайруулах сайхан
Чимэд-Осор баавайн бүтээсэн дүр бүхэн сайхан
Чин ван Ханддорж шиг эх оронч байх сайхан
Шөнийн тэнгэрт одод анивчих сайхан
Шөрмөст бөхчүүдийн гараа дэвээ сайхан
Эгшиглэнт эх Янжинлхамд сүсгэлэх сайхан
Ээрэм талд хамхуул хийсэх сайхан
Юм бүхэн утга агуулах сайхан
Юндэн Гөөгөө шиг эр хүн байх сайхан
Яндангийн нүхээр оч үсрэх сайхан
Янзаган хүрээтэй санамсаргүй таарах сайхан

Үндэсний цэцэрлэгт хүрээлэн,
2019 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр



ДӨХӨМИЙН БАЯН ОВОО МИНУ

Далай сайхан орны минь
Үзэмж төгс гоо урлал
Дархан хилийн харуул
Дөхөмийн Баян Овоо
Өвгөд дээдсийн үеэс
Үлгэр туульсын домог хуучлан
Өнөө бидэндээ өртөөлөн иржээ
Ирээдүй хойчдоо түүчээлэн хүргэнэ ээ!
Алтан Овоо, Дөхөмийн Баян Овоо
Ахан дүүсийн барилдлагатай юм гэсэн
Алсаас хоёр биенээ харуулдан
Арсан, зааны дүрээрээ
Алсрах он цагийг элээсээр
Хэдэн зуунаас ч юм бэ
Овоогоо тахин сүжиглэсээр
Хэдэн үеэрээ ч юм бэ
Овоондоо мөргөн сүсэглэсээр
Лус сахиусаа аргадах нь
Монгол хүний сэтгэлгээ!
Нуур далайгаа хайрлах нь
Монгол түмний ухаан!
Уул усаа баясах нь
Морин хуурын татлага!
Тэнгэр эрхсээ шүтэх нь
Судар тарнийн эрчим!
Дүнэгэр өвгөдөө дурсах нь
Хүмүүн бидний ёсон!
Сунагар талаа туулах нь
Шандаст хүлгийн хурд аа!
Хүн байгаль хүйн холбоотой
Хүн үгүй бол байгаль үгүй
Байгаль үгүй бол хүн үгүй
Хүн байгалийн шүтэлцээ
Дөхөмийн Баян Овоо минь
Дөрвөн улиралдаа налгар
Хүж дэлхийн сондор
Дөхөмийн Баян Овоо минь
Дөрвөн зүгтээ цацлагатай
Өргөн түмний дуулалтай
Найман зүгтээ дуурсгалтай
Найрын дугараан өргөлтэй
Арван зүгтээ алдартай
Алт эрдэнэсийн өлгий билээ
Алсаас зорин очиход
Аав шиг минь угтдаг
Эргэн санан дурсахад
Ээж шиг минь үгүйлэгддэг
Захгүй талын эзэн
Цэнхэр тэнгэрийн багана
Дөхөмийн Баян Овоо минь
Дархан хилээ манан зогсоо
Хаан уул аа Та!
Даяар олондоо хүндлэлтэй
Сүүн уул аа Та!

Сүхбаатар аймаг, Баяндэлгэр сум, "Ширээт" баг,
2019 оны 8 дугаар сарын 4-ий өдөр



МОНГОЛ БАЯР

Цасны баяр насны баяр
Цантай өвлийн жавартай баяр
Хүн бүхний хүсдэг баяр
Хүч тамир өгдөг баяр аа!
Мөсний баяр мөнхийн баяр
Мөнгөн чаргатай цоглог баяр
Зон олноороо хөгждөг баяр
Зочин гийчид ирдэг баяр аа!
Цэргийн баяр эрсийн баяр
Цэгцэрсэн жагсаалаар алхдаг баяр
Аавын хөвгүүдийн догдолдог баяр
Алтан мөрдэстний шагмалын баяр аа!
Улсын баяр бүхний баяр
Уудам орноороо цэнгэдэг баяр
Дэнж хотойтол наадаг баяр
Дэлхийн сонорыг мялаадаг баяр аа!
Энэ бүх баяр Эх орны минь
Дуутай, хууртай баяр аа!

"Соёмбо" сонин,
2020 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр



ЖАРГАЛАН

Танан цагаан гэртээ
Аав минь налайн суух нь
Айл гэрийн жаргалан
Таана, хөмүүл дэлхсэн
Цайдам талд мал бэлчих нь
Амар амгалан хөдөөгийн жаргалан
Уураг шаргалтан зөөхийцсөн
Аагтай цайгаа самрах нь
Ээжийн минь жаргалан
Уудам талдаа дөрөө жийн хатируулж
Уртын дуугаа шуранхайлах нь
Эртээ адуучны жаргалан
Гэр дүүрэн инээдээр
Баясал бэлэглэх нь
Хөөрхөн үрсийн минь жаргалан
Гэгээн хайранд нялхран
Бодлоо хуваалцаж алхах нь
Идэр залуусын жаргалан
Гэрэлт ирээдүйгээ цогцлоон
Алсын аянд дөрөөлөх нь
Ухаант хүмүүсийн жаргалан

2014 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр

ШИЛИЙН БОГД-ХИЛИЙН БОГД ОО!

Шилийн Богд Та
Хилийн Богд оо!
Шил шилээ дарсан гийчид
Тасраа нь үгүй хайрхаан!
Торой Банди, Тогос Чүлтэм ... гээд л
Халх даяар нэрээ дуурсгасан
Салхи исгэрүүлсэн сайн эрчүүд
Гуурст хүлгийнхээ алтан тоосоор
Туурайн тамга хээлж
Хувьхан заяаныхаа төөргөөр
Хурмастын цэнхэр ододтой
Ханьсаж явсан өлгий!
Дөмөн хүлгийн төөргөөнд
Дөрөө жийн исгэрч
Дөрвөн хавтгайн хээлэнд
Омог оршоон эрхшээж
Ядарсан зүдэрсэн олноо
Яс махнаасаа хайрлаж
Задарсан бялдууч нэгний
Заяа төөргийг тонилгосон
Шилийн сайн эрчүүд
Шилийн Богдын үр сад аа
Тэнхээт хүчит бөхчүүдийн
Омгийг хурцалсан хэвнэг
Тэлмэн жороо морьдын
Шандсыг сорьсон дэвсэг
Үеийн үедээ дуурсгалтай
Амьд бурхаан Та!
Үрийн үрдээ мөнхрөөстэй
Шүтээн бурхаан Та!
Шилийн Богдын оройд
Уртын дууны шуранхайтай
Шилийн Богдын оройд
Уухайн дууны хадаатай
Шилийн Богдын оройгоос
Хилийн багана тодорно
Шилийн Богдын оройгоос
Хүний нутаг манантана
Захгүй талаа манан зогссон
Цэрэг уул Шилийн Богд оо Та!
Заяа тавилангийн төөргөөр
Эх орноо хамгаалсан Хилийн Богд оо Та!

Үндэсний цэцэрлэгт хүрээлэн,
2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр




ЭХ ОРОН

Алтан Дарь эх овоондоо
Сүсэглэн залбирах нь эх орон
Аяны харгуйг эмхэрдэн
Уртын дуу аялах нь эх орон
Ганга нуур цэлэлзэн цэнхэртэх нь эх орон
Гангар хун чуулан шаагилдах нь эх орон
Шилийн Богдын оройд
Цас малгайлах нь эх орон
Шинэхэн танилцсан амрагууд
Хослон дуулах нь эх орон
Өглөөний наран уулын цаанаас мандах нь эх орон
Өсөж яваа хүү адуундаа мордох нь эх орон
Өргөн талд зээр шаргалтах нь эх орон
Өндөр өвгөдөө дурсан санах нь эх орон
Ээжийн чанасан цайны уур тооноор савсах нь эх орон
Эзэгийг, ааруулыг элээ шүүрэх нь эх орон
Эмээлтэй морь сужганд зүүрмэглэх нь эх орон
Энд ч, тэнд ч болжмор жиргэх нь эх орон
Аавын үнэртэй дээлийг
Авдранд нандигнах нь эх орон
Алсаас ирсэн айлчин гийчдээ
Хүндэтгэн угтах нь эх орон
Эрдүү цээл хоолойгоор
"Эр бор харцага"-ыг уянгалуулах нь эх орон
Эрэмгий хүчтэй бөхчүүд
Дэвэн шавах нь эх орон
Эрхий мэргэн харваачид
Нумаа шивших нь эх орон
Эмээлт хурдан хүлгүүд
Тоосоо өргөх нь эх орон
Энхрий бяцхан үрс
Үнэгчлэн нойрсох нь эх орон
Эрдэмд шамдсан хүүхдүүд
Ирээдүйд тэмүүлэх нь эх орон
Ээрэм талд салхи исгэрэх нь эх орон
Эмэгчин чоно бэлтрээгээ тэжээх нь эх орон
Энэтээх довноос үүр хаяарах нь эх орон
Эрдэмтэн мэргэд бодлоо уралдуулах нь эх орон
Гантиг ордонд түшээд чуулах нь эх орон
Гадаа, гэрт Төрийн дуулал эгшиглэх нь эх орон
Төр улс амгалан орших нь эх орон
Төрөлх нутгаа эр цэрэг хамгаалах нь эх орон
Алтайн их уулс
Амгалан дүнснийх нь эх орон
Алтан шаргал говь
Халиуран зэргэлзээтх нь эх орон
Дорнын уудам тал
Домог хуучлах нь эх орон
Догшин ноён хутагтын
"Үлэмжийн чанар" шуранхайлах нь эх орон
Хөвчийн буурал тагтад
Хөхөө донгодох нь эх орон
Хөл хүндтэй бүсгүй
Алгуурхан дунших нь эх орон
Монгол зон хөгжин дэвжих нь эх орон
Морин хуур уянгалан цуурайлах нь эх орон

"Сансар" хороолол,
2016 оны 2 дугаар сарын 29-ний өдөр





Дугаарын зочин

Н.Пүрэвдаш: "ХАРАНГА"-ЫН ТҮҮХ ГУЧААС Ч ОЛОН ЖИЛИЙН ӨМНӨ БИЧИГДЭЖ ЭХЭЛСЭН

Бөмбөр хөгжмийн ноён оргил болсон Төрийн соёрхолт, "Харанга" хамтлагийн бөмбөрчин, МУГЖ Н.ПҮРЭВДАШТАЙ ярилцлаа.



Танд энэ өдрийн мэндийг хүргэе. "Харанга" хамтлаг ойрын өдрүүдэд ямар уран бүтээл дээр төвлөрч ажиллаж байгаа талаар ярилцлагаа эхэлье ...

"Монгол цэргийн өдөр", Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 99 жилийн ойн босгон дээр танай сонины зочин болж уригдсандаа баяртай байна. Бидний нөхөрлөл олон жилийн настай. Урт удаан хугацааны шалгуурыг давсны эцэст "Харанга" хамтлагийн дуунууд сонсогчдын зүрх, сэтгэлд амьдарсаар байна. Харин энэхүү урт замын аялалд хөгжим л биднийг нэгдмэл байлгаж чадсан. Үзэгчдийн шимтэж, дурлаж, хайрлаж сонсдог бидний уран бүтээлүүдийн цаана нэр их хөдөлмөр, цаг хугацаа оршдог. Хөгжим бүрийн найруулга ямар байх, хэрхэн ялдуулах гээд олон зүйлийг нухацтай бодох шаардлагатай. Ер нь уран бүтээл гэдэг цаг хугацааны шалгуурыг давж, шүүгдэн хүнд хүрдэг онцлогтой. Өөрөөс тань хойших хоёроос гурван үеийн сонсогчид ч яг тань шиг мэдрэмж, таашаал, бас ухаарлыг аваасай гэж уран бүтээлүүдэд туурвидаг болохоор бидний уран бүтээлүүд маш сайн шүүгдсэн байдаг. 1990-ээд оноос өнөөдрийг хүртэл дуулагдахаар байгаа "Харанга"-ын дуунуудаас үүнийг харж болно. Оны өмнөхөн буюу Улаанбаатар хот үүсэн байгуулагдсаны түүхт 380 жилийн ойгоор Я.Одсүрэн "Харанга" хамтлагийн бөмбөрчин, гитарчин/бид хоёрт Гавьяат жүжигчин цол хүртээсэн. Дараа дараагийн уран бүтээлд маань ёстой л "ташуур" өгсөн гэж болно. Үүнийг дагаж их хариуцлага ноогдож байгаа. Бидэнд цаашид төлөвлөсөн зүйл олон. Манай хамтлагийг сонсдог мянга мянган шүтэн бишрэгчдийнхээ "цангааг" тайлсан бүтээлүүдийг туурвисаар байх болно.

Аав тань Хилийн отрядад тусгай үүрэг гүйцэтгэж байсан гэсэн ...

"Миний аав Нэмэх намайг таван настай байхад өөд болсон. Би балчир байсан ч гэлээ зарим зүйлийг нь санадаг юм. Миний

сэтгэлд мартагдахааргүй хоногшиж үлдсэн дурсамж, хүүхэд насны дурдатгал олон бий. Айлын бага болоод ч тэр үү, ёстой л өвөр дээр нь тоглодог, хоёр ахаасаа илүү эрх мэдэлтэй, танхил хүүхэд байлаа. Аавыг анх автобус баазын жолооч байх тэр үед одоогийн Үйлдвэрчний эвлэлийн Соёлын төв ордонд нүүдлийн кино театр байрлаж байв. Нэгэн өдөр кино театр хөл гишгэх зайгүй боллоо дүүрдэг юм байна. Би үзвэрийн танхим руу ороходоо газар унаж, тэр чигтээ мөлхөж явсаар гар, хуруугаа гишгүүлээд тамтаггүй юм болсон. Дүүгээ харсангүй гээд аав хоёр ахыг маань загнаж, зэмлээд сүйд. Бас нэгэн удаа дүрсгүй зан хөдлөөд ах нарыгаа дагаж айлын хашаа давж ороод элдвийн юм сониучирхаж байгаад манаачид нь баригдаад баларсан. Хоёр ах бараг нүд ирмэхийн зуур л хашаа давж зүтсэн, би яах вэ уйлаад л хоцорсон. Галууг дуурайж хэрээ хөлөө хөлдөөнө гэгч л болсон доо. Харин аав маань оройжин ах нарын "тоосыг гэвсэн". Залуу байхдаа тоогоогүй ч нас ахихын хэрээр аавынхаа талаар их судлах боллоо. Хүний амьдралын жам л юм хойно. Аавын хувьд 1945 онд Замын-Үүдийн Хилийн отрядад тусгай үүрэг гүйцэтгэж, алба хаасан юм билээ. Чөлөөлөх дайны 73 жилийн ойгоор Оросын цахим хуудсанд аавын минь маршал Х.Чойбалсангийн өмнө номхон зогсож буй зураг гарч ирсэн. Аавын хувцас нэлээд гандсан харагдаж билээ. Ингээд энэ нь сэжүүр болж би аавынхаа тухай илүү ихийг мэдэхийн төлөө эрэл хайгуул хийж эхэлсэн л дээ. Аавын "Бид ялав", "Онц хилчин" тэмдгийн нь үнэмлэхийг ээж хадгалж байсан юм. ХХЕГ-аас 1994 оноос өмнөх үед хамаатуулах бүх материалыг ТЕГ-т шилжүүлсэн учир нөгөө "Онц хилчин" тэмдгийн үнэмлэхээ архивд нь авч очоод шүүлгэтэл 14 хоногийн дараа аавтай минь холбогдох баримт, мэдээлүүд олдсон. Тодруулбал, 1945 онд цэрэгт татагдан Завхан аймгийн Хилийн 12 дугаар отрядад очсон байгаа юм. Тэндээс шигшмэл

залуусаас бүрдсэн 9 дүгээр отрядад багтсан гэдгийг нь олж мэдсэн. Тус отрядын хувьд Чөлөөлөх дайны үед ямар хүнд нөхцөлд үүрэг гүйцэтгэсэн гэдэг нь төсөөлөхөд ч бэрх.

Зэвсэгт хүчинд алба хааж байсан Н.Пүрэвдашийн талаар бидний чихэнд хүрч амжаагүй, төдийлөн мэддэггүй зүйлс байдаг л байх. Сонин сайхан түүхээсээ хуучлахгүй юу?

"Цэргийн хөгжмийн сургуулийг анх байгуулалцсан Г.Дашпунцаг гэж хүн миний хүргэн ах байгаа юм. Аавыг өнгөрснөөс хойш ээж гурван хүүхэдтэйгээ үлдэж хоцроход Г.Дашпунцаг ах "Сахилгагүй багыг чинь би хүн болгоё" гэсэн гэдэг. Ингээд тавдугаар ангиа төгсөөд 1971 онд Ардын Армийн 013 дугаар ангид хөгжмийн салааны сурагчаар томилогдож, бөмбөрчин бэлтгэх сургалтад хамрагдсанаар 13 настай хүүхэд 20 настай ах нарын дунд ажиллаж "жинхэнэ цэрэг" амьдралын амтыг мэдэрсэн юм. Сонирхуулахад, намайг тус ангид томилогдож очихоос жилийн өмнө буюу 1970 оны 12 дугаар сарын 5-ны өдөр хөгжмийн салаа нь анх байгуулагдсан түүхтэй юм билээ. Ингээд 1976 оноос мэргэжлийн хөгжимчин болж ЗХЖШ-ын ҮЖҮНХ-д хөгжимчин ахлагчаар томилогдон ажиллах болсон. Нийтдээ 19 жил 8 сар ажиллаад Зэвсэгт хүчнээсээ гарч 1989 оноос өнөөдрийг хүртэл "Харанга" хамтлагтайгаа урлагт зүтгэж байна даа. ҮЖҮНХ-д байхдаа их эрэлтэй бөмбөрчний нэг байжээ гэж бодогддог. Цэргийн ансамблийн тоглолтод оролцохоос гадна Улсын циркээс ирэх урилга ч тасардаггүй байв. Би өдөртөө ҮЖҮНХ-д, орой болохоор циркэд очиж тоглодог байлаа. Тэр хэрээрээ орлого сайтай хөгжимчин болсон. Одоо харин ёстой хүний чихэнд барагтаа хүрээгүй түүх сонирхуулья. 1977 онд Монгол-Зөвлөлтийн хоёр талын хэерийн сургууль зохион байгуулахад би урлагийн бригадын бүрэлдэхүүнд багтаж оролцсон юм. Ингээд командлагчийнхаа тушаалаар эсрэг талын хэерийн штабт урлагийн тоглолт үзүүлэхээр болж очоод бид бага зэрэг "нээдэлчихсэн" юм л даа. Эхлээд хоол цай, идэж ууна гээд манайхан ч хойш суучихлаа шүү. Тэгж байтал эсрэг талын командлагч, хурандаа генерал Б.Цог ирээд, учир явдлыг мэдэн ихэд уурлалаа. Бидний хандыг хага дарсан шүү. "Миний олзны хүмүүс шахуу болчхоод юун хоол, цайсаг юм" гээд хөтөлбөрт байсан орос дуунуудыг болиулж биднээр дан ардын дуу дуулуулсаар байгаад явуулсан нь санаанаас гардаггүй юм.

"Харанга" хамтлагийн түүх анх "Соёмбо" нэрээр бичигдэж эхэлсэн. Тэгэхээр "Харанга" 30-аас ч олон жилийн түүхтэй болж таарч байна ...

"1977 онд Ц.Чулуунбаатар, 1978 онд Ц.Энхманлай, 1981 онд Я.Одсүрэн маань ҮЖҮНХ-д орж ирсэн. Бид тус тусдаа, өөр өөр группт байсан учраас бие биеэ нэг дээвэр дор байдаг л гэж мэднэ.

Гэхдээ тухайн үед ҮЖҮНХ-ийн дэргэд "Соёмбо" гэж хамтлагт хамт тоглодог болсноос хойш бие биеэ илүүтэй мэдэх болсон. Бид чинь "Соёмбо" хамтлагаас төрөн гарцаасан учраас яалт ч үгүй "Харанга"-ын түүх аль эрт бичигдэж эхэлсэн гэсэн үг. Рок хамтлаг байгуулах талаар Ц.Энхманлай, Я.Одсүрэн хоёр Төрийн шагналт хөгжмийн зохиолч, урлаг судлаач, доктор С.Соронзонболдтой их ярьдаг байж. Манай хоёр хамтлагтаа сайн бөмбөрчин хайгаад олохгүй байхаар нь нэг удаа С.Соронзонболд та хоёр хажуудах бөмбөрчнөө олж харахгүй юм гээд тэднийг бага зэрэг гоочилсон гэсэн шүү. Тэд намайгаа анзаараагүй хэрэг л дээ. Бид дөрөв "Соёмбо" хамтлагт байхдаа Монголын радиод "Өргөн хангайн нутаг", "Ганган борлог" зэрэг дуунуудыг бичүүлсэн. 1983 онд нөхөд маань "Хамтлаг байгуулья, ажлаасаа гарчих" гэж ятгах болсон юм. Гэтэл би ганц, хоёрхон жил болоод л тэтгэвэртээ гарах гээд байдаг. Рок хамтлаг байгуулах санааг гэр булийнхэн минь дэмжсэнгүй. Дэмжсэн хүн хуруу дарам цөөн. Хамгийн их нөлөөлсөн хүн бол эхнэрийн минь ах байсан. Армийн хурандаа, "Рапорт" Баадай гэвэл хүмүүс мэднэ. Цэргийн олон албан тушаалд томилогдон ажиллаж байсан ах маань надад "Тэтгэвэртээ гараад найман сар болж байхад намайг хэн ч тоохоо больсон. Үнэн гэвэл энэ л байна. Чи хожимдоогүй дээрээ өөрийнхөө хүүснээр амьдар, дуртай зүйлээ хий. Миний араас битгий орчих. Хожим үр хүүхэд чинь чамаар бахархана. Одоо армиас гар" гэсэн. Ингээд л би Манлай, Оогий хоёрынхоо саналыг хүлээж аваад, урт замын аянд бэлдсэн дээ. Гэхдээ ҮЖҮНХ-ийнхөөс надад өгсөн зүйл их. Би тэндээс ажил хөдөлмөрийн гараагаа эхлээгүй бол өдий зэрэгтээ явахгүй байсан.

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад оролцож байгаа Зэвсэгт хүчний 7781 дүгээр ангийн захирал, бригадын генерал П.Доржсүрэнд та бөмбөр хэрхэн тоглохыг заасан гэсэн. Хэзээнээс багш вэсийн барилдлагатай болсон бэ?

"Олон жилийн өмнө болсон явдал л даа. Анх П.Доржсүрэн генерал манай ажил дээр ирэхдээ надад бөмбөр зааж, намайг шавиа болгооч гэж шулуухан хэлсэн. Монгол төрийн генерал хүн ороод ирэхээр сүртэй гэж жигтэйхэн, цаанаа бас омогшмоор. Үүнд нь ч би их бэлгэшээгээд шууд л зөвшөөрч шавиа болгосон. Харин бөмбөрийг хоёр, гуравхан сарын дотор эрчимтэй сурсан шүү. Тэр хүн ажлынхаа хажуугаар цаг, заваа гаргаж тоглосоор тийм хэмжээнд хүрсэн. Хэрэв зээ над шиг анхнаасаа хөгжим тоглоод явсан бол өндөр амжилт үзүүлэх ч юм билүү гэж бодогддог. П.Доржсүрэн генерал цаанаасаа өгөгдөлтэй, авьяастай хүн.

Германы Мерседес Бенз, Сиенес Никсдорф, Даймлер Крайслер компаниуд "Харанга"

хамтлагийг дэмжиж, цомгийг нь хэвлүүлж байсан түүх бий. Ийм бардам түүхтэй хамтлагийг Монголоос хайгаад олохгүй байх ...

"Яг үнэн. Монголд байхгүй, дэлхийд ч ховор. Бид Германы 50 гаруй мянган хамтлагаас шалгарсан шилдэг хамтлаг болох "Загасчны хүүхдүүд" хэмээх хамтлагийг 1997 онд эх орондоо урьж тоглуулсан. Мэдээж бид ч өөрсдийн уран бүтээлээ толилуулна шүү дээ. Энэ үед л "Харанга" маань Германы нэртэй продюсер, хөгжмийн зохиолчдын нүдэнд өртөж эхэлсэн байх. Ямар нэгэн жалга довын үзэл байсангүй. Биднээс урлаг гэж юу байдгийг, яагаад урлагийг дэлхийн хэл гэдгийг мэдэрсэн болов уу. Ер нь германчууд сонгодог хөгжмийн олон зуун жилийн түүх, соёлтой, нэрт төлөөлөгчидтэй шүү дээ. Тийм дээ ч авьяасыг үнэлэх талаар өөгүй үндэстэн байна лээ. Дан ганц хөгжмийнхөн нь гэлтгүй тэргүүлэх компаниудын удирдлагууд нь ч "нүдтэй, чихтэй" санагдсан.

МУГЖ Х.Лхагвасүрэнгийн хувьд хэзээ хамтлаг орсон бэ?

"Хөгжмийн зохиолч, "Андууд" хамтлагийн ахлагч байсан Р.Хатанбаатар манай Лхагваагийн аав. Түүнийг ард түмний гавьяат ч гэж хэлдэг. "Соёмбо" хамтлагт байхаас л бид Лхагваагийн аавыг мэддэг байсан л даа. Х.Лхагвасүрэн их хөдөлгөөнтэй, реп бүжиглэдэг хүүхэд байлаа. Тааралдах л юм бол цаахдыг чинь өрөөндөө дуудаад бүжиглүүлнэ. Энэ үеэс л Лхагвааг хамаатнаас дутуугий мэддэг болж сүүлд "Харанга" үүсгэн байгуулагдахад манай Чука дагуулаад ирж билээ.

Тоогонд нь олон жил чанагдсан хүний хувьд та Монголын рок поп урлагийн ирээдүйн талаар ямар гэгээлэг зүйлийг төсөөлдөг вэ?

"The HU" хамтлаг хамгийн том жишээ. Урлагаар дамжуулан бид юунд хүрч болохыг харлаа. Цаашид соёл, урлагийн салбарыг төрийн бодлогоор дэмжээд өгөх хэрэгтэй. Хуучных шиг энэ салбарт шаардлагатай боловсон хүчнийг нь бэлдэхэд төр, засаг анхаарал хандуулах цаг нь ирсэн. Бас мэдрэмжтэй, мэргэшсэн, боловсролтой инженер, техникийн ажилтнууд үгүйлэгдэж байна. ОХУ-д гэхэд л хөгжмийн бага, дунд, их, дээд сургуулиудыг төгссөн болон удирдаач мэргэжилтэй хүмүүс дуу бичлэгийн студид ажилладаг.

Гэр бүлийн тань талаар асууж амжилгүй байсаар энд хүрлээ. Таны амжилтын ард бат зогсоор ирсэн ханийнхаа талаар ярихгүй бол алдас болох биз ...

"Бид танилцаад 40 гаруй жил болж байна. Залуу байхад энд тэнд хөгжим тоглоод явчихаар гэр бүлдээ зарцуулах цаг гардаггүй байв. Одоо ч тийм үе цөөнгүй. Тэглээ гээд намайг орхилгүй урлагт хайртай занд минь дасаж, эвлэрсэнд баярладаг. Миний хань П.Отгонтуяа ОХУ-д гутал загварын мэргэжлээр суралцаж төгссөн.

Ярилцсанд баярлалаа.

Дэслэгч Ц.ЭНХ-ОРГИЛ


Үндэсний бахархал,

ӨВ СОЁЛ

БЭЛЭГИЙН ГУРАВДУГААР ЦУВААНД

Хошууч Дэмбэрэлийн анги баатарлаг улаан цэргийн армийн ялалтыг бахархаж, улаан армид явуулах бэлгийн шлоныг хуралдуулах ажилд идэвхтэйгээр оролцож байна. Бэлэн цугларсан төгрөг 713, морь 3, сарлаг 3, хонь ямаа 14 болжээ. Байлдагч Пүрэв, Шагдарсүрэн, Молом нар байлдаан дуустал сар бүр 5 төгрөгийг бэлэглэж байх ба мөн Дандар сар бүр 8 төгрөгийг байлдаан дуустал бэлэглэнэ гэж илэрхийлжээ. Энэ ангийн байлдагчид бол бэлгийн ажилд өргөнөөр оролцож байна. Эмнэлэг дээр хэвтэж байгаа байлдагч Цэндээс 25 төгрөг бэлэглэв.

Байлдагч Дандар
Батлан хамгаалахын төв архивын сан хөмрөгөөс. "Улаан од" сонин. 1943.02.03. Дугаар 27 /1288/. Хуудас 129



АХМАД НАСТАН, АРХАГ ХУУЧ ӨВЧТЭЙ ХҮМҮҮС ЮУ АНХААРАХ ВЭ

Коронавирусийн халдвар (COVID-19)-аар ахмад настан, зурх судас, чихрийн шижин, артерийн даралт ихдэлт, хавдар, бөөр, амьсгалын замын өвчтэй болон дархлаа дарангуйлах эм хэрэглэдэг хүмүүс өвчлөх эрсдэлтэйг Дэлхийн эрүүл мэндийн байгууллага анхааруулж байна. Иймд:

- Эмчийн хяналтад тогтмол байх;
- Эмийг эмчийн зааврын дагуу хэрэглэх;
- Холбоо барих хүний утасны дугаартай байх;
- Давс, чихэр, өөх тос багатай хоол, хүнс хэрэглэх;
- Халуун, бүлээн шингэн зүйл ойр ойрхон уух;
- Сайн унтаж амрах;
- Тайван байх;
- Дулаан хувцаслах, даарахгүй байх;
- Хөнгөн дасгал, хөдөлгөөн хийх;
- Ханиаж, найтааж байгаа хүнээс хол байх;
- Олон нийтийн газраар явахгүй байх;
- Амны хаалтыг байнга зүүх;
- Гараа сайтар савандаж угаах;
- Бие тавгүйрхвэл Яаралтай тусламжийн төвийн 103, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 1800-2000 утсаар зөвлөгөө авах, харьяа өрхийн эрүүл мэндийн төвд хандахыг зөвлөж байна.

СОЁМБО СОНИН
"Соёмбо" сонин 96 дахь жилдээ хэвлэгдэж байна.
Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА, Д.НАЦАГДОРЖ

Эрхлэгч
Хурандаа
Батжаргалын
ОТГОНБЯАР

Эхийг "Соёмбо" сонин
релактад бэлтгэж,
"Соёмбо принтинг" хэвлэх
үйлдвэрт хэвлүүлэв.

*Зар, рекламьг хямд нийтэлнэ.
*Зар, рекламьн үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.
*Зохиогчийн үзэл болон сониний нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.
*Тус сонин мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот,
Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон
Индекс 10018
И-мэйл хаяг:
Mil_newssoyombo@yahoo.com
Утас: 70001029